

ХЭРЭГЦЭЭГҮЙ ЛУЙВАР



2012 ОНЫ 12 САР

Бэлтгэсэн:

Оюу Толгойн Хяналт ТББ, Accountability Counsel, Urgewald,
CEE Bankwatch, London Mining Network, мөн Bank Information Center

ТОВЧООН

Оюу Толгойн зэс\алт\мөнгө олборлох уурхайн үйл ажиллагаанаас үлэмж хэмжээний сөрөг нөлөө нийгэм болон байгаль орчинд учрах тул Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК), Европын

сэргээн босголт, хөгжлийн банк \ЕСБХБ\-аас энэ төслийг А Ангилалын төсөлд багтаасан. Уурхайн менежментийг эрхлэх Рио Тинто\Туркуайз Хилл компаниудын охин компани болох Оюу Толгой ХХК-аас Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ \БОННУ\г ОУСК, ЕСБХБны А Ангиллын төсөлд тавьдаг шаардлагад нийцүүлэн хийлгүүлж 2012 оны 8 дугаар сарын дундуур буюу найман сар хойшлуулан байж нийтэд танилцуулсан.

БОННУ-гээг төслийн дизайн боловсруулах болон хөрөнгө оруулалтын эрсдлийн үнэлгээний явцад санхүүжилтийн шийдвэр гаргахаас өмнө уг төсөл олон улсын стандартуудад нийцэж байгаа эсэхийг тогтоох зорилготой хийлгэдэг юм. Бидний нягталж үзсэн Оюу Толгой төслийн БОННУ нь **бүрэн бус** болон **өнгөрсөн хугацааны нөлөөллийг үнэлж** байгаа тул дээрх шаардлагуудад нийцэхгүй байна.

Хэлэлцүүлж буй энэ БОННУ нь Дэлхийн Банк тэргүүтэй олон улсын санхүүгийн байгууллагуудаас хөрөнгө оруулалт хийх шийдвэрийн үндэслэл болох гэж байгаа тул алдаа мадагтай үнэлгээнд үндэслэн шийдвэр гаргах нь нутгийн бүлгүүдийн эрх ашиг болон хөрөнгө оруулагч талуудын нэр хүндэд сөргөөр нөлөөлнө гэж үзэж байна.

Төсөл нь нутгийн иргэд болон байгаль орчинд үлэмж сөрөг нөлөө үзүүлээд байгаа. Иймд, энэхүү БОННУ-ний тайланд зөрчилтэй, алдаа мадагтай тусгагдсан зүйлүүд дээр өөрийн саналыг дэвшүүлж, доорхи зөвлөмжүүдийн дагуу зохих арга хэмжээ авагдтал санхүүжилтийн хэлэлцээрийг зогсоохыг зөвлөж байна.

- **БОННУ-г бүрэн гүйцэд хийж зохих ёсоор хэлэлцүүлэх.** БОННУ-нд: ○ Үйл ажиллагааны (үйлдвэрлэлийн) Менежментийн Төлөвлөгөө; ○ Хамаарах байгууламжуудын нарийвчилсан үнэлгээ; ○ Усны хэрэглээнээс үүсэх хам болон хил дамнасан нөлөөллийн үнэлгээ; ○ Улс төрийн, эдийн засгийн эрсдлийн үнэлгээ хийж журмын дагуу хэлэлцүүлэх.
- Бүрэн гүйцэд БОННУ-г **хянах хөндлөнгийн экспертудын баг** байгуулж гидрологи, тоосны бохирдол, байгалийн төрөл зүйлийг хамгаалах, хаягдлын менежмент, газар ашиглалт ба нүүлгэн шилжүүлэлтийн ажиллагааг хянуулах.
- Хөндлөнгийн мэргэжлийн баг бүрдүүлж **нүүрсээр галлах цахилгаан станцын БОННУ** болон холбогдох баримт бичгүүд, түүний дотор Дэлхийн банкны *Хөгжил ба Уур амьсгалын өөрлөлтийн Стратеги Хүрээ бодлогын Нүүрсний төслүүдийг шалгаруулах үзүүлэлтүүд* бодлогоор шаарддаг альтернатив шийдлийн анализ хийлгүүлж хянах.
- Элдэв арга хэрэглэн зохисгүй нөхөн олговорын гэрээнд гарын үсэг зуруулах одоогийн практикийн зогсоож, **гэрээг ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандартын 5-д нийцсэн эсэхийг тогтоох, нийцүүлэх** талаар хэлэлцээ хийх.
- БОННУ-нд дурдсан бүх **судалгаа, тайлангууд** байрших вебсайтын холбоосыг өгөх эсвэл компанийн вебсайтад тавих замаар **олон нийтэд нээлттэй болгох**. Жагсаалтыг 9. Зөвлөмж бүлгээс харна уу.

ГАРЧИГ

Товчоон	2
Гарчиг	3
Оршил.....	3
БОННУ-ний агуулга болон хугацаа.....	4
Эрсдлийн шинжилгээ.....	7
Нөлөөлөлд өртөх хүн ам болон эмзэг бүлгүүд.....	8
Усны нөөцийн менежмент	19
Байгалийн төрөл зүйл	22
Дэд бүтэц буюу төслийн бусад байгууламжууд	21
Хам нөлөөлөлүүд	25
Зөвлөмж.....	28
Холбоо барих хаяг.....	30

ЖИЧ: Нягтлалын холбогдох хэсгүүдэд ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандартын зүйл заалтыг зөрчсөн байдлыг *Бодлогын зөрчил* гарчигтэй хайрцагт багтаан тусгаж өгсөн болно.

Энэ Төслийн хувьд ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандартын аль хувилбар мөрдөгдөх асуудал дээр бид ОУСК-ийн мэргэжилтнүүдтэй санал нийлэхгүй байгаа юм. 2009 онд хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсан, ОУСК-иас төслийг судлах ажлыг 2011 онд эхэлсэн зэргээс үзвэл 2006 оны Үйл ажиллагааны Стандартыг мөрдөнө гэж ОУСК-ийн баг үзэж байгаа юм. Гэтэл БОННУ нь 2012 оны 7 дугаар сарын 31 гэсэн огноотой бөгөөд энэхүү тайлан, ОУСК-ийн төслийн баримт бичгийг 2012 оны 8 дугаар сарын сүүлчээс өмнө нийтэд зарлаагүй тул 2012 оны 1 дүгээр сараас хүчин төгөлдөр болсон Үйл ажиллагааны Стандартыг мөрдөх учиртай гэж манай баг үзэж байгаа юм.

Ийнхүү хоёр өөр байр суурьтай байгааг харгалзан, БОННУ-нд нийт найман \8\ бодлогын зарчим ба стандартыг зөрчсөн байгааг 2006 ба 2012 Үйл ажиллагааны Стандартаас иш татан харуулсан болно.

1. Оршил

Монгол улсын өмнийн Говьд орших Оюу Толгой уурхайг төслийн үйл ажиллагаанаас үлэмж хэмжээний нийгмийн болон байгаль орчны нөлөөлөттэй байх тул А Ангилалын төсөл хэмээн Олон

улсын санхүүгийн корпорац (ОУСК), Европын сэргээн босголт, хөгжлийн банк \ЕСБХБ\-аас тодорхойлсон. Энэ уурхайн менежментийг эрхлэх Рио Тинто\Туркуайз Хилл компаниудын охин компани болох Оюу Толгой ХХК-иас Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ \БОННУ\-г ОУСК, ЕСБХБ-ны энэ төрлийн төсөлд тавигддаг шаардлагад нийцүүлэн хийлгүүлж 2012 оны 8 дугаар сарын дундуур буюу найман сар хойшлуулан байж нийтэд танилцуулсан.

Бид энэхүү төслийн хөгжлийг олон жил ажиглаж ирсэн олон улсын иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ бөгөөд Оюу Толгойн \ОТ\ төслийн БОННУ-г олон улсын стандартууд, сайн туршлагад нийцэх эсэхийг нягтлан үзэж зөрчилтэй байгааг тогтоогоод байна. Энэхүү БОННУ нь Дэлхийн Банкны ОУСК, Австралийн Экспортын Санүүжилт, Даатгалын Корпорац (EFIC), АНУ-ын Экспорт-Импорт Банк тэргүүтэй олон улсын санхүүгийн байгууллагуудаас хөрөнгө оруулалт хийх шийдвэрийн үндэслэл болох гэж байгаа тул алдаа мадагтай үнэлгээнд үндэслэн шийдвэр гаргах нь нутгийн бүлгүүдийн эрх ашиг болон хөрөнгө оруулагч талуудын нэр хүндэд сөргөөр нөлөөлнө гэж үзэж хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг хойшлуулахыг зөвлөж байна.¹

2. БОННУ-ний агуулга болон хугацаа

Байгалийн нөөц ашиглах төслөөс учрах үлэмж хэмжээний сөрөг нөлөөллийг харгалзан үйл ажиллагааны тал бүрийг хамарсан БОННУ хийлгэх шаардлагыг төсөлдөө санхүүжилт гориглогч байгууллагуудад ОУСК, ЕСБХБ, бусад олон улсын санхүүгийн байгууллагууд \ОУСБ\ тавьдаг юм. БОННУ-гээг төслийн дизайн боловсруулах болон хөрөнгө оруулалтын эрсдлийн үнэлгээний явцад санхүүжилтийн шийдвэр гаргахаас өмнө уг төсөл олон улсын стандартуудад нийцэж байгаа эсэхийг тогтоох зорилготой хийлгэдэг юм. Бидний судалж үзсэн Оюу Толгой төслийн БОННУ нь *бүрэн бус* болон *өнгөрсөн хугацааны нөлөөллийг үнэлж* байгаа тул дээрх шаардлагуудад нийцэхгүй байна.

2.1 БОННУ- ний бүрэн бус байдал

БОННУ нь аливаа төслийн хэрэгжих хугацааны бүх үе шатууд (дизайн, барилга, үйлдвэрлэл эхлэх зөвшөөрөл, үйлдвэрлэл, үйлдэрлэлийг зогсоох, уурхайн хаалт болон зарим тохиолдолд хаасны дараах үе ордог)-ын нөлөөллийг тогтоох, тогтоосон нөлөөллийг бууруулах, саруулах стратегийг багтаах зорилготой хийгддэг. Олборлох үйлдвэрлэл нь үйл ажиллагааны бүх үе шатандаа байгаль орчин, нийгэмд үлэмж сөрөг нөлөөлөл учруулдаг тул бүх шатны үйл ажиллагаанд нарийвчилсан үнэлгээ хийгдэх ёстой байдаг.

Оюу Толгой төслийн БОННУ-нд уурхайн үйл ажиллагааны бүх шатны нөлөөллийг үндэс болгосон гэжээ:

¹ Дэлхий банк групп – ялангуяа ОУСК – БОННУ-г зохих журмын дагуу хийгээгүй төслүүдэд санхүүжилт хийж ноцтой байгаль орчны болон нийгмийн сөрөг үр дагавар дагуулсан төслүүд дэмжпэг түүхтэй. Перу дахь Янакоча ба Конга уурхайн эсэргүүцэл ба аллагууд, Өмнөд Африкийн Марикана бх Копананг уурхай эсвэл Гватемала дахь Марлины уурхайн жишээнээс харж болно.

Энэхүү БОННУ нь Өмнөд Оюу дахь алт-зэсийн ордыг ашиглах ил уурхайн барилгын ажил, дөрвөн жилийн дараа эхлэх блок-кэйвинг технологиор олборлох Хойт Хюгогийн далд уурхайн нөлөөллийг тогтооход оршино. Уурхайгаас олборлох хүдрийг өдөрт 100.000 тонныг боловсруулах хүчин чадал бүхий баяжуулах үйлдвэр, цаашид өдөрт 160,000 тон хүдэр боловсруулах хүчин чадал болон түүнийг дэмжихэд шаардагдах дэд бүтцээс бүрдэж байгаа болно. Дээр танилцуулсан байгалийн баялаг ашиглах үйлдвэрлэлийн төслийг боловсруулах, барьж байгуулах, үйлдвэрлэх, үйл ажиллагаагаа зогсоох болон хаалтын шатууд, тэдгээрт холбогдох дэд бүтцийг энэхүү БОННУ-нд “Төсөл” гэж тодорхойлсон болно.²

Гэтэл, барилгын шатны нөлөөлөл болон менежментийн төлөвлөгөөг нарийвчлан тусгасан атлаа, үйлдвэрлэл болон хаалтын төлөвлөгөө нь тодорхой бус зарим тохиолдолд бүр орхигдсон байна. Орхигдсон хэсгүүд нь Компанийн зүгээс төслийг гурван үе шат – үйлвэрлэлийн өмнөх, үйлдвэрлэлийг эрчимжүүлэх болон тогтвортой үе шаттай хэмээн хэсэгчлэн танилцуулах оролдлоготой холбоотой юм. Жишээлбэл, Хяагдлын менежментийн төлөвлөгөө болон Хяагдал овоолгын менежментийн төлөвлөгөөний хэсгүүдэд “энэхүү хэсгийг зориуд орхигдуулсан бөгөөд зохих хугацаанд боловсруулж гаргах үйлдвэрлэлийн менежментийн төлөвлөгөөнд багтаах болно”³ гэж. Хяагдлын менежмент нь бохирдол болон усны нөөцийг зүй бусаар ашигладаг олборлох үйлдвэрлэлийн хамгийн өндөр эрсдэлтэй хэсэг тул орхигдуулсан байгаа нь энд тусгасан менежментийн төлөвлөгөөний хамгийн ноцтой дутагдал байна.

Байгаль орчин, Нийгмийн Менежментийн Төлөвлөгөөний Хүрээ баримт бичигт үйлдвэрлэлийн менежментийн төлөвлөгөөний багц, түүний дотор Уурхайн хаалтын төлөвлөгөө нь хэвлэхэд бэлэн болоогүй байгааг хүлээн зөвшөөрсөн бөгөөд ОУСК-ийн вебсайд дахь мэдээллээс үзвэл 2012 оны 12 дугаар сарын 31 хүртэл бэлэн болохгүй аж. Усны нөөцийн хэрэглээнд үлэмж нөлөөтэй байх Ажилчдын орон сууц хөгжүүлэх хөтөлбөрийн БОННУ зэрэг бусад чухал менежментийн төлөвлөгөөнүүд 2013 оны 12 дугаар сарын 31 хүртэл бэлэн болохгүй гэнэ⁴. Одоогийн хэлэлцүүлж буй БОННУ нь 2002-оос 2011 онуудын хооронд бэлтгэгдсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнүүдээс бүрдэж байгаа тул тайлангийн бүлэг хэсгүүдэд багтсан баримт мэдээлэл нь хоорондоо зөрчилдсөн, төөрөгдөл төрүүлсэн зүйлүүд байна. Эдгээр баримт мэдээлэл нь олон улсын стандарт хангаж байгаа гэх баталгаа байхгүй тул энэхүү мэдээлэлд үндэслэн санхүүжилтийн шийдвэр гаргах нь эртэдсэн хэрэг болно.

Бодлогын Зөрчил

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 1, догол мөр 4 (2012): “Шаардлагатай тохиолдолд үүнд [үнэлгээнд] биет эд хөрөнгийг хөгжүүлэх төслийг боловсруулах шатнаас эхлэн хэрэгжих нийт хугацааны бүх үе шатуудыг (дизайн, барилга, үйлдвэрлэл эхлүүлэх, үйлдвэрлэл, хаалт эсвэл зарим тохиолдолд хаалтын дараах шатны ажиллагаа) оруулах.”

² Оюу Толгойн БОННУ, (see <http://www.ot.mn/?q=en/node/2679>), Бүлэг А4, р 5

³ Оюу Толгойн БОННУ, Бүлэг D10 and D9 respectively

⁴ IFC, Оюу Толгой ХХК-ийн БОННУ-ний дүгнэлт, E & S Action Plans

<http://www.ifc.org/ifcext/spiwebsite1.nsf/651aeb16abd09c1f8525797d006976ba/d8a67e4647784ed385257a62005d32e1?opendocument>

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 1, догол мөр 6 (2006): “аливаа төслийн үйл ажиллагааны гол гол үе шатууд, түүний дотор барилгын өмнөх, барилгын, үйлдвэрлэлийн, үйлдвэрлэл зогсоох болон хаалтын үе шатуудын Эрсдэл ба Нөлөөллийг мөн шинжилнэ.”

2.2 Өнгөрсөн хугацааны нөлөөллийн БОННУ

Төлөвлөлт болон санхүүжүүлэх шийдвэрийн бодитой үндэслэл болох баримт мэдээлэл болгохын тулд БОННУ-г төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө нийтэлж, хэлэлцүүлж зөвшөөрүүлдэг ёстой. Оюу Толгойн уурхайн хайгуулын ажил 1997 онд эхэлж 2009 онд Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурах хүртэл үргэлжилсэн бөгөөд барилгын ажил 2010 эхэлсэн гэдэг. Гэтэл, БОННУ нь 2012 оны 7 дугаар сарын 31 гэсэн огноотой буюу уурхайн барилгын ажил 94% -ийн гүйцэтгэлтэй үеийн үнэлгээ байна. БОННУ нь зөвхөн барилгын ажлын менежментийн төлөвлөгөөг агуулж байгаа тул энэ нь өнгөрсөн хугацааны нөлөөллийн үнэлгээ буюу зорилгоо хангахгүй үнэлгээ юм.

Бие даасан зөвлөх Роберт Гудландын дүгнэснээр:

Энэхүү БОННУ нь барилгын үе шат дуусч байхад нөлөөллийг үнэлж үйлдвэрлэлийн нөлөөлөл, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх мэдээллээ тусгаагүй байгаа нь учир дутагдалтай. Мөн үйлдвэрлэлийн шатны нөлөөллийн үнэлгээ хоцорч хийгдэх гэж байгаа нь бүр ноцтой дутагдал юм. БОННУ хийдэг зарчмыг ийм хэрэгцээгүй луйвар болгож байгаа нь Айвенхоу Майнзын ЕГЗ Роберт Фридландын Оюу Толгойн орчны мэдлэгээ “тэр орчинд хүн гэж байхгүй, газар нь тэгш, ширэнгэн ойгүй бас ТББ-ууд байхгүйд \Оюу Толгойн\ төслийн сайн талууд оршино”⁵ (Jan. 21st 2012, The Economist)⁶ гэж тодорхойлсонтой нь дүйцэж байна.

БОННУ нь санхүүжилтийн баримт бичгийн хувьд, Компаниас сөрөг нөлөөлөл ба эрсдлийг саруулахын тулд хийгээд өнгөрсөн биш *юу хийх* гэж байгаа тухай өгүүлэх ёстой юм. БОННУ-ний үйл явц нь хугацаа шаарддаг ажиллагаа гэдгийг зөвшөөрөх боловч энэ БОННУ хийгдсэн байдлаас харвал барилгын үе шатны нөлөөллийн үнэлгээг хамгийн оновчтой байлгахын тулд барилга эхлэхээс өмнө хийсэн байх атал барилгын ажилтай зэрэгцүүлэн хийсэн бололтой байна. Олборлох үйлдвэрийн нөлөөлөл ба менежментийн төлөвлөгөөний хувьд ч мөн адил – үйлдвэрлэлийн менежментийн төлөвлөгөөг нийтээр хэлэлцүүлээгүй байхад эхний ээлжийн олборлох үйл ажиллагаа эхлэх гэж байна.

⁵ . Угаас цөөн хүн амтай Монголын нэлээд олон нь сөрөг нөлөөлөлд өртөж, говийн экосистем ширэнгэн ойгоос илүү эмзэг өртөмтгий байх магадлалтайг мэдэхгүй Роберт Фридландын Оюу Толгойн тухай хийсэн мэдэгдэл нь алдаатай гэдэг нь илт байна. Хэдийгээр тэр үед Ханбогодод ТББ-ууд байгаагүй байж болох боловч өнөөдөр тэнд хэд хэдээрээ байгуулагдаж Оюу Толгойн уурхайн сөрөг нөлөөллийг хянахад үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Харамсалтай нь энэхүү үл тоомсорлосон хандлага нь ганц Роберт Фридландаар зогсохгүй Рио Тинтотой харилцах болон энэ БОННУ-ний хэлэлцүүлгийн байдалд ч илэрсээр байна.

⁶ I See attached: Goodland, R. 2012. Mongolia: The Oyu Tolgoi Copper & Gold Mine Project – Comments on Chapter D1 of the ESIA: “Environmental and Social Management Plan Framework”, p 1. ⁷ Мөн тэнд.

“Урьдчилан сэргийлэх нь эмчилгээнээс хямд тусч бас илүү үр дүн өгдөг”⁷ гэдэг боловч БОННУ–г ажил эхлэхээс өмнө хийгээгүй тул одоо барилгын үе шатны олон төрлийн нөлөөлөл хуримтлагдсан газар хэдийн хэмжээний хохирол учирсныг тогтоох боломжгүй байна.

3. Эрсдлийн шинжилгээ

Олборлох төслийн төрөл ба цар хүрээг харгалзан түүний эдийн засаг, байгаль орчин ба улс төрийн эрсдлийг нарийн шинжилж үнэлэх шаардлагатай байдаг. Төсөлд хөрөнгө оруулалт хийхээс өмнө дээрх эрсдлүүдийг нээлттэй үнэлж хөрөнгө оруулагч, бусад талуудад төсөл боловсруулагчдын мэдээллийн үнэн зөвийг хянах боломж олгодог ёстой юм. Оюу Толгойн хувьд, энэхүү олон хэсгээс бүрдэх үнэлгээнд төслийн эрсдлийн үнэлгээг нэг бол орхигдудулсан эсвэл ил тод бус учраас мэдээлэл байхгүй байгаагийн дээр БОННУ-нд оршиж буй бусад дутагдлуудыг тооцвол улам ноцтой болж байгаа юм.

БОННУ-нд Голланд өвчний тухай зурвасхан дурдсан байх боловч⁸ МУ-д улам нэмэгдэж, гүнзгийрч байгаа “баялгийн үндсэрхэх үзэл” –ийн эрсдлийг шинжээгүй байна. Оюу Толгой Улаанбаатарт болж буй улс төрийн өөрчлөлтөд өртөхөөс дархлаагүй гэдэг нь Засгийн газраас 2009 онд байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээг өөрчилж уурхайн эзэмшлийн 34% -ийг 51% хүргэх оролдлого хийснээс харагдана. Ерөнхийдөө шудрага бус гэрээ болсон тул гэрээг эргэж харах эрмэлзлийг ойлгож болох боловч энэ нь өнөөгийн парламент дахь орлогын хуваарилалтын талаарх зөрчлийн илрэл юм. Парламентын зарим гишүүд Оюу Толгойн болон бусад уурхайн орлогыг нийт хүн амд жигд хүртээхийг хүсч байгаа ч нөгөө хэсэг нь өөрөө баяжих сонирхолтой байгаа юм. Баялгийн орлогын хуваарилалтын маргаан нь мөн ОУСБаас эдийн засгийн төрөлжүүлэлтийн талаар туслалцаа үзүүлэхгүй байгаагаас шалтгаалж байна. Дэлхийн банкны сүүлчийн МУ-тай Түншлэх Стратегид жишээлбэл “уул уурхайд түшиглэсэн тогтвортой хөгжил” чиглэсэн байна^{9,10}. Бусад эдийн засгийн салбар, жишээлбэл ХАА-д үзүүлэх тусламж нь хязгаарлагдмал цар хүрээтэйгээс гадна хөрөнгийн хувьд уурхайн салбараас хавьгүй бага хүртэж байна.

Эрсдлийн үнэлгээ нь мөн төслийн болзошгүй уналтыг үнэлэх ёстой юм. Өөрөөр хэлбэл, БОННУ нь нутгийн иргэдийн гадаргын усны нөөцөд учирч болзошгүй физик болон химийн гамшигийг багтааж үнэлэх болон энэ төрлийн гамшиг нэрмээс болж нийгэмчлэгдэх г.м. төрлийн улс төрийн эрсдлийг тооцох ёстой юм.

БОННУ-нд жишээлбэл анхны блок-кэйвинг технологиор олборлох төслөөс (Хюго) үлдэх Улаанбаатар хотын төв хэсгийн хэмжээний хонгилын нөлөөллийг тусгаагүй байна¹⁰. Байгаль орчин⁷ болон ажилчдад⁸ хүнд хохирол учруулах эрсдэлтэй блок- кэйвингээс үүсэх нөлөөллийг төслийн нийт эрсдлийн үнэлгээнд зайлшгүй тусгах нь нэн чухал. Хонгил нь малчдын хэрэглэж буй гар худгуудын ойр орчмын чулуулгийг нураах аюултай тул Компани нь уурхайн олборлолт эхлэхээс өмнө нарийн үнэлгээ хийлгэх шаардлагатай. “Хөрсний суулт

⁷ БСТ-ийн судлаач Пол Робинсоны дүгнэснээр: хонгилын бус нь угаас тогтворгүй тогтоц болж нөхөн сэргээх, зугтаж дүүргэх боломжгүй болох юм. ОТ урт хугацааны нөлөөллийн тухай нутгийн малчдын санаа зовч байгаа зүйлүүдийн нэг бол энэ нөхөн сэргээх боломжгүй сарны хонхор мэт тоомохон хонгил үлдэх юм.

⁸ БОННУ-нд Австрали дахь Нортпаркс уурхайн блок-кэйвинг хийсэн сайн туршлагынхаа тухай өгүүлжээ. Гэтэл Рио Тинтогийн үйл ажиллагааны арга барилаас 4 уурхайя амь алдсан туай дурдаагүй байна. Аюулгүй ажиллагаа хангах хурдыг үл харгалзан олборлосноос болсон нь тогтоогдсон байдаг. <http://eagcg.org/common/pdf/NorthParkesCoronial.pdf> ¹³ ОТ БОННУ, Бүлэг А4, х. 21 ¹⁴ Гудланд, х. 6

эсвэл нуранги үүсч болзошгүй” гэж БОННУ-ний блок-кэйвингийн тухай хэсэгт өгүүлсэн боловч зөвхөн байж болзошгүй эрсдэл үү эсвэл зайлшгүй бий болох нөлөөлөл гэдгийг тогтоосон эсэх¹³ нь тодорхойгүй байгаа юм.

⁸ Оюу Толгойн БОННУ, Бүлэг С7

⁹ Дэлхийн банкны Группээс МУ-тай Түншлэх Стратеги 2013-2017

¹⁰ км Х 2.5 км хонгил, ОТ БОННУ, Бүлэг А4, х 23

Дээрх эргэлзээ, үнэлгээ хийсэн байдлаас харахад төслийн вебсайт дээр сурталчилж буй эдийн засгийн өргөн ашиг өгөжийн амлалтаа биелүүлж чадахгүй болох нөхцөл бодитой байж чадахаар байна. Үүгээр барахгүй, Менежментийн гэрээ, бусад холбогдох тайлангуудыг нийтэд нээлттэй болгоогүй нөхцөлд монголын нийгэм дээрх амлалтуудын үнэн зөвийг үнэлэх боломжгүй байгаа юм. Харамсалтай нь БОННУнд дурдсан мэргэжлийн экспертиудын тайлангууд нийтэд нээлттэй бус байгаа нь Компанийн зүгээс БОННУ-нд салбарынхны мэргэжлийн үнэлгээ хийгдсэн гэсэн мэдэгдлийн үндэслэлийг үгүйсгэж байна. Энэ байдал болон тал бүрийг шинжилсэн эрсдлийн үнэлгээ эсвэл нөлөөлөл үр өгөөжийн гэрээ¹⁴ байхгүй байгаа нь төслийг анх эхлэх цагаас тахал мэт дагаж ирсэн ил тод бус байдлын үндэслэл болж байна.

4. Нөлөөлөлд өртөх хүн ам болон эмзэг бүлгүүд

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ боловсруулах явцын бүх шатанд нөлөөлөлд өртөх хүн ам (төсөлд шууд өртөх нутгийн бүлгүүд)- ыг үр бүтээлтэй оролцуулах нь сөрөг нөлөөллийг бууруулахын гол арга болно. Ялангуяа эмзэг бүлгүүд – эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настан болон боломжоор хязгаарлагдмал уугуул иргэдэд – тохирсон зөвлөлдөх тусгай стратеги боловсруулах шаардлагатай. Хэрэв нөлөөлөлд өртсөн хүн амын зарим гишүүдийн газар зүйн эсвэл эдийн засгийн байршил алдагдсан бол тэдний амьжиргааны түвшинийг сэргээх эсвэл улам дээшлүүлэх нөхөн олговрын хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай. Оюу Толгой төслийн нөлөөллийг үнэлэх аргачлал нь энэ шаардлагыг хангахгүй байгаа нь түгшүүртэй байна. Мөн БОННУ-нд “нутгийн өргөн олон нийтийн дэмжлэг” гэдгийг юугаар хэмжиж байгаа нь тодорхойгүй бөгөөд ОУСК ч үүнийг нотолж чадаагүйгээ хүлээсэн.¹⁴

4.1 Өмнөговийн нүүдэлчин малчдыг “уугуул иргэд” ангилалд багтаах үндэслэл

Сүүлийн жилүүдэд, Дэлхийн Банкны Групп, ЕСБХБ, Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ) зэргээс дэлхий даяар уугуул иргэдийн эрхийг хамгаалах бодлого¹⁵ боловсруулж нэвтрүүлж ирсэн. Хэдийгээр эдгээр бодлогуудад Чөлөөт, Урьдчилсан, Мэдээлэл бүхий Зөвшөөрөл (FPIC) зарчмыг суулгаж өгсөн ч 2007 онд НҮБ-ын Уугуул иргэдийн эрхийн тунхаглал⁹ батлагдан гартал бүх нийтээр хэрэглэх боломжгүй гэсээр бүрэн хэрэгжээгүй ирсэн юм.

Рио Тинто мэтийн хувийн компаниуд ч уугуул иргэдийн эрхийг хамгаалахаа нийтэд зарлан тунхагласан байдаг. Хэдийгээр бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн “уугуул иргэд”-ийн тодорхойлолт байдаггүй ч эдгээр иргэд өөрсдийгөө уугуул гэж үздэг бөгөөд нийгмийн үндсэн соёлоос ангид оршдог юм. Рио Тинтогийн Др.

⁹ http://www.un.org/esa/socdev/unpfii/documents/DRIPS_en.pdf

Крис Андерсон энэ жил Оксфамын арга хэмжээнд дээр тодорхойлсноор Компани нь аливаа “газарт түшиглэсэн”¹⁰ бүлгүүдийг уугуул гэж үзнэ гэсэн нь Монголын нүүдэлч малчин иргэд энэ бүлэгт багтана гэсэн үг.

Өмнөговийн нүүдэлч малчид нь газарт түшиглэсэн болон эртний нүүдэлч соёлыг тээгчийн хувьд өөрсдийгөө уугуул гэж үздэг байна. Иймд уугуул иргэд өөрийн өвөрмөц байдлаа зарлан хамгаалуулах эрхтэй бөгөөд компани, банк зэрэг байгууллагууд тэдний уугуул эрхийг үгүйсгэх эрх байхгүй. Компани нь ОУСК-иас

¹⁴ ОУСК, Байгаль орчин, нийгмийн үнэлгээний хураангуй, ВС.

¹⁵ Namely IFC PS 7 and World Bank OP/BP 4.10; EBRD Performance Requirement 7; ILO Convention 169.

хөрөнгө оруулалт гориглож байгаагийн хувьд БОННУ-нд ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 7-д заасан уугуул иргэдийг тодорхойлох удирдамж үйлчлэх учиртай. Энэ Үйл ажиллагааны Стандартад заасан шинжүүдийн гурвыг дагуу Монголын нүүдэлч малчид уугуул иргэд хангаж байгаа тул уугуул иргэд гэж тодорхойлогдох бөгөөд Стандартын 7 заасан бүх хамгаалалтыг эдлэх эрхтэй.

Нэгдүгээрт, малчид өөрсдийгөө уугуул иргэд гэж тодорхойлдог бөгөөд нийгэм үүнийг хүлээн зөвшөөрч байгаа ¹¹ тухай дээр дурдсан. Хоёрдугаарт, тэд төслийн эргэн тойронд орших газарт өвөг дээдсээсээ уламжлан авсан газартаа нүүдэллэн амьдардаг. Энэхүү олон зуун жилийн түүхтэй газарт түшиглэсэн байдал нь улирлын болон тодорхой давтамж бүхий нүүдэллэх амьдралын хэв маягаар илэрхийлэгдэнэ. Гуравдугаарт, малчид нийт нийгмээс өөрийн өвөрмөц соёл болон эдийн засгийн заншлаар ялгагдах бөгөөд энэ нь тодорхой бүс нутагт байгалийн баялагт түшиглэн нүүдэллэн амьдрах хэв маягаар илэрхийлэгдэнэ. Эцэст нь, ҮАС 7-д заасан дөрөвдэх шинжийн хувьд уугуул иргэдийн хэрэглэдэг хэл хэллэг нь өвөрмөц бөгөөд нийт нийгэмээр хэрэглэдэгээс алгардаг. Хэдийгээр бие даасан хэлний түвшинд хүрэхгүй ч нүүдэлч малчдыг тодорхойлоход чухал үүрэгтэй.

Удирдамжийн тэмдэглэлүүдэд санхүүжилт гориглогч (Үйлчлүүлэгч) нь нутгийн иргэдийг уугуул иргэд бүлэгт багтах эсэхийг нарийн судалж, түүний дотор дараах арга хэмжээ авч болохыг зөвлөсөн байдаг. Үүнд: хууль эрх зүйн үйлчлэлийн судалгаа болон олон улсын хуулийн дагуу хүлээх үүргүүд; архивын судалгаа, угсаатны зүйн судалгаа, түүний дотор соёл, зан заншил, заншлын хууль болон оролцоо бүхий үнэлгээ хийнэ. Үүний дээр, Үйлчлүүлэгч энэ ажлыг хийж гүйцэтгэх мэргэжлийн эксперт авч ажиллуулна.”

ҮАС 7-д заасан шалгууруудын гуравыг хангахын зэрэгцээ нүүдэлч малчид энэ Стандартад хамгаалахыг зорьсон бүлгийн шалгуурыг мөн хангаж байгаа юм. Удирдамжийн тэмдэглэлүүдэд нүүдэлч хүн амыг хамгаалах тухай маш тодорхой “богино зайнд улирлын чанартай нүүдэллэх бөгөөд өвөг дээдсийн нутаглах газруудад улирлын хамааралтай уялдан амьдардаг” ²⁰ гэж тодорхойлсон байна. Нүүдэлчин малчид газрын хамаарлаа алдвал асар их хэмжээгээр хохирох тул тэднийг Нөлөөлөлд өртөх бүлгүүд хэсэгт “эмзэг” гэж томъёолж хамгаалах нь хангалтгүй байна.

¹⁰ <http://www.oxfamamerica.org/campaigns/extractive-industries/community-consent-index>

¹¹ See, e.g.: Minority Rights Group International. July 2011. *State of the World's Minorities and Indigenous Peoples 2011 – Mongolia*. (“Mongolian herders, mostly minorities and indigenous peoples, were confronted with severe drought and a harsh winter, forcing thousands of them to abandon their nomadic life. . . .”) <http://www.unhcr.org/refworld/docid/4e16d36711.html> ²⁰ IFC, PS 7 Guidance Note 7 (2012).

Гэтэл БОННУ-нд энэ төсөлд ҮАС-ын 7-р заалт хамаарахгүй хэмээн “зохисгүй байдлаар үгүйсгэсэн”¹² байгаа юм. БОННУ-нд нүүдэлч малчид ҮАС 7-д заасан уугуул иргэдийн шалгуурыг хангаж байгаа эсэхийг тогтоох үнэлгээ хийгдсэн нотолгоо алга байна. БОННУ-нд зүгээр л “Энэ төсөлд хамаарах уугуул иргэд байхгүй. Малчин бүлгүүд нь соёлын ч, угсаатан зүйн ч хувьд Монгол улсын нийгмийн бүрэлдэхүүн хэсэг юм. Төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан бий болох нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн дарамтад уламжлалт амьдралын хэв маяг нь өртөх тул малчин бүлгүүдийг “эмзэг” бүлэгт багтаасан болно.”¹³ Малчид өөрсдийгөө уугуул иргэд гэж тодорхойлдог, газар зүйн хувьд төсөл хэрэгжих газарт өвөг дээдсийн нутагт тодорхой нутаглах газруудад хамааралтай буюу ОУСК-ийн стандартын шалгуурын шинжүүдийг хангаж Уугуул Иргэд гэж хамгаалах үндэслэл байсаар атал дээрх байдлаар тодорхойлсон нь наандаж л оновчгүй

гэлтэй¹⁴. БОННУ-нд судалгаа шинжилгээ хийгээгүй атлаа нүүдэлч малчид уугуул иргэдийн статус эдлэхгүй гээ тодгтоосон нь ҮАС-ын 7.8-ийг илт зөрчиж байна.

¹² See attached: Gleason, J. 2012. *Evaluation of the Environmental and Social Impact Assessment (ESIA) for the Oyu Tolgoi Copper and Gold Project and the application of IFC and EBRD Performance Standards*. ELAW, p 1.

¹³ ОТ БОННУ, Бүлэг А2, х 27.

¹⁴ *Удирдамжийн тэмдэглэлүүдэд санхүүжилт гориглогч (Үйлчлүүлэгч) нь нутгийн иргэдийг уугуул иргэд бүлэгт багта эсэхийг нарийн судалж, түүний дотор дараах арга хэмжээ авч болохыг зөвлөсөн байдаг. Үүнд: хууль эрх зүйн үйлчлэлийн судалгаа болон олон улсын хуулийн дагуу хүлээх үүргүүд; архивын судалгаа, угсаатны зүйн судалгаа, түүний дотор соёл, зан заншил, заншлын хууль болон оролцоо бүхий үнэлгээ хийнэ. Үүний дээр, Үйлчлүүлэгч энэ ажлыг хийж гүйцэтгэх мэргэжлийн эксперт авч ажиллуулна.* IFC, PS 7 Guidance Note 6 (2012). ²² Үйл ажиллагааны Стандарт 7, хх. 13-15.

Бодлогын зөрчил

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 7, догол мөр 5 (2012): ”Энэхүү Үйл ажиллагааны Стандартад “Уугуул Иргэд” гэсэн томъёог дараах нийгэм ба соёлын өвөрмөц шинжийг ямар нэгэн хэмжээнд агуулсан нийгмийн бүлэгт хамааруулан ерөнхий утгаар хэрэглэнэ:

- Өөрийгөө өвөрмөц уугуул соёл бүхий бүлэг хэмээн тодорхойлдог бөгөөд бусад бүлгүүд хүлээн зөвшөрдөг;
- Газар зүйн хувьд төсөл хэрэгжих газарт тодорхой нутаглах газартай буюу өвөг дээдсийн нутаглах газар болон түүний байгалийн нөөцөөс хамааралтай;
- Заншлын соёл, эдийн засаг, нийгэм ба улс төрийн институт бүхий үндэсний нийгэм соёлоос тусдаа оршдог; эсвэл чөлөөт
- Өвөрмөц хэл, аялгуу, олонхи тохиолдолд үндэсний албан ёсны эсвэл тухай бүсийн хэлнээс ялгардаг.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 7, догол мөр 5 (2006): ”Энэхүү Үйл ажиллагааны Стандартад “Уугуул Иргэд” гэсэн томъёог дараах нийгэм ба соёлын өвөрмөц шинжийг ямар нэгэн хэмжээнд агуулсан нийгмийн бүлэгт хамааруулан ерөнхий утгаар хэрэглэнэ:

- Өөрийгөө өвөрмөц уугуул соёл бүхий бүлэг хэмээн тодорхойлдог бөгөөд бусад бүлгүүд хүлээн зөвшөрдөг;
- Газар зүйн хувьд төсөл хэрэгжих газарт тодорхой нутаглах газартай буюу өвөг дээдсийн нутаглах газар болон түүний байгалийн нөөцөөс хамааралтай;
- Заншлын соёл, эдийн засаг, нийгэм ба улс төрийн институт бүхий үндэсний нийгэм соёлоос тусдаа оршдог; эсвэл чөлөөт
- Уугуул хэл, аялгуу, олонхи тохиолдолд үндэсний албан ёсны эсвэл тухай бүсийн хэлнээс ялгардаг.”

4.2. Төсөл үйл ажиллагаа эхлүүлэхээс өмнө нүүлдэлч малчдаас Чөлөөт, Урьдчилсан, Мэдээлэл бүхий зөвшөөрөл авах шаардлагатай

Малчин иргэд мэт уугуул иргэдийн уламжлалт эзэмшлийн газар ба байгалийн баялагт нь нөлөөлөл учруулах, авч хэрэглэх эсвэл нүүлгэн шилжүүлэх байдлаар эрхийг хөндөх тохиолдолд төслүүд тэдний чөлөөт, урьдчилсан, мэдээлэл бүхий зөвшөөрөл авсан байх шаардлага тавигддаг²². Компани нь малчдыг уугуул хэмээн тодорхойлоогүй нь энэ шаардлагад нийцэх оролдлого хийгээгүй байна. Төслийн барилгын ажил дуусах гэж байгаа тул төслийн нэлээд хэсэгт жинхэнэ утгаар чөлөөт, урьдчилсан, мэдээлэл бүхий зөвшөөрөл авах боломжгүй болсон ч олон арван малчин өрх газар нутгийн болон эдийн засгийн байршлаа алдаж байгааг

харгалзан цаашдын ажиллагаандаа, тухайлбал цахилгаан станц барих явцад зөвшөөрлийг авах шаардлагатай.

Бодлогын зөрчил

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 1, догол мөр 32 (2012): “Уугуул иргэдэд сөрөг нөлөө учруулах төслүүдийн хувьд Үйлчлүүлэгч нь зөвлөлдөх хэлэлцүүлгийн үйл явцыг хэрэглэх, зарим тохиолдолд чөлөөт, урьдчилсан, мэдээлэл бүхий зөвшөөрөл авсан байна (FPIC).”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 7, догол мөр 15 (2012): “Үйлчлүүлэгч нь Уугуул иргэдийг уламжлал эсвэл заншлаар нийтийн эзэмшилд буй уламжлалт нутаглах газар ба байгалийн нөөцөөс нүүлгэн шилжүүлэхээс зайлсхийх төслийн дизайны альтернатив хувилбар гаргаж судалсан байна. Хэрэв зайлшгүй нүүлгэн шилжүүлэх бол чөлөөт, урьдчилсан, мэдээлэл бүхий зөвшөөрөл аваагүй бол төслийг хэрэгжүүлэхгүй.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 7, догол мөр 9 (2006): Үйлчлүүлэгч нь төслийн нөлөөлөлд өртөх уугуул иргэдийн бүлгүүд байх тохиолдолд төлөвлөлтийн шатанд аль болох эрт харилцаа тогтоож , хэрэгжих нийт хугацаанд үргэлжлүүлэн харилцана. Төслийн нөлөөлөлд өртөх уугуул иргэдийн бүлгүүдтэй бол тэдэнтэй чөлөөт, урьдчилсан болон мэдээлэл бүхий зөвлөлдөх үйл явц хэрэгжүүлж, тэдэнд шууд хамаатай асуудлууд, жишээлбэл сөрөг нөлөөлөл сааруулах төлөвлөгөө, хөгжлийн үр шим ба боломжуудыг хуваарилах, төслийн хэрэгжилтийн асуудлууд дээр дээр мэдээлэлтэйгээр оролцох боломжийг бүрдүүлнэ. Нутгийн бүлгүүдийн оролцооны хэлбэр нь соёлын хувьд зохистой байх, Уугуул иргэдэд нөлөөлөх болзошгүй нөлөө ба эрсдлийн хэмжээтэй дүйцүүлсэн байна.

4.3 Сонирхогч талуудтай зөвлөлдөх үйл явц учир дутагдалтай бөгөөд нутгийн хүн ам төслийг өргөн олноороо дэмжиж байгаа тухай нотолгоо алга байна

Оюу Толгойн төслийн нөлөөлөлд өртсөн хүн амыг гурван бүлэгт хувааж болох юм: Ханбогд сумын төвд оршин суугчид, Ханбогд сумын Гавлиут, Жавхлант багуудын малчин өрхүүд болон уурхайгаас Хятадын хил хүртэл татсан дэд бүтцийн коридорын дагуу оршин суух Баян-Овоо сумын малчин өрхүүд болно. Нөлөөлөлд өртсөн өрхүүдийн дийлэнх нь сумын төвөөс 15-20 км оршин суудаг тул сумын төвд хүрч очих нь амаргүй, холбооны дэд бүтэц нь хязгаарлагдмал тул интернет ба үүрэн телефоны холбоо хүртээмжгүй байдаг. Иймд Компаниас өрхүүдтэй гэрт нь очиж зөвлөлдөх хэлбэрийг голлохоор сонгосон нь гайхах юмгүй¹⁵. Гэхдээ зөвхөн ганцаарчилсан зөвлөлдөх хэлбэрийг ашиглаж байгаа нь ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандартын “дарамтаас ангид байлгах” зарчимд нийцэхгүй байгаа юм.

Малчдын хувьд гэртээ орж ирсэн хүнийг зочин хэмээн үзэж зочны санал болгосон зүйлийн талаар үзэл бодлоо илэрхийлээд байх, ялангуяа сөрөх магадлал бага. Иймд ганцаарчилсан зөвлөлдөх хэлбэрээр бодит санал авах боломжгүй тул соёлын хувьд зохисгүй байна. Малчид болон сумын төвийн оршин суугчдын дунд бүлгээр хэлэлцүүлж зөвлөлдөх тохиолдолд малчид чөлөөтэй ярихаас эмээхгүй байх магадлал илүү өндөр байдаг.

Гэхдээ сумын төвд цуглуулж бүлгээр хэлэлцүүлсэн ч баримт бичгүүдийг хэлэлцүүлгээс өмнө хүргүүлдэггүй, мөн малчдын болон сумын төвийн хүн амын хэрэгцээний талаар тогтож ярилцахын оронд Компани өөрөө юу хийсэн тухай ярихыг чухалчилдаг. Жишээлбэл, уул уурхайн ажиллагаанаас агаар, хөрс, усанд учрах бохирдол эсвэл нутгийн хүн амын эрүүл мэндэд учрах сөрөг нөлөөллийг саруулах төлөвлөгөөний талаар

¹⁵ OT ESIA, Chapter D14, p 39

ганц ч удаа мэдээлэл өгч хэлэлцүүлээгүй байна. Малчдад өөрийгөө болон малаа сөрөг нөлөөллөөс хэрхэн хамгаалах талаар мэдээлэл огт өгөөгүй байна.

Оюу толгой болон бусад уурхайн компаниудын үйл ажиллагаанд өртөж итгэл алдсан малчид зохион байгуулалтанд орж Говийн газар шороо г.м. ТББ-ууд байгуулан нэгдэж байна. Эдгээр бүлгүүд Оюу Толгой, Таван Толгойгоос Гашуун Сухайт хүрэх тээврийн зам мэт уул уурхайд холбогдох төслүүдийн эсрэг эсэргүүцлийн жагсаал цуглаан хийж, өлсөглөн зарлахад бэлэн байна. Говийн бусад 5-10 км хол зайд оршин сууж хооронд тэр болгон уулзалдаад байдаггүй малчид зохион байгуулалтад орно гэдэг нь өөрөө ер бусын үйл ажиллагаа юм.

Энэхүү орон нутгийнхны, түүний дотор нутгийн захиргааны улам нэмэгдэж буй эсэргүүцэл¹⁶ нь Оюу Толгой төслөөс нутгийн иргэдтэй зөвлөлдөх арга хэлбэр нь БОННУ-нд тусгасан байдлаар аргачлалын хувьд зохисгүй, хүссэн үр дүнд хүргэхгүй байгаагийн нотолгоо бөгөөд үүнийгээ эргэж харах хэрэгтэй. Дээр дурдсанчлан, БОННУ-нд нутгийн иргэдийн өргөн дэмжлэгийг юугаар хэмжиж байгаагаа тодорхойлоогүй бөгөөд үүнийг нь ОУСК ч хүлээн зөвшөөрсөн байна.¹⁷

Бодлогын зөрчил

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 1, догол мөр 30 (2012): “Үр бүтээлтэй зөвлөлдөх нь хоёр урсгалтай үйл явц... Үйлчлүүлэгч нь өөрийн зөвлөлдөх үйл явцын арга хэлбэрийг нөлөөлөлд өртөх бүлгүүдийн сонгосон хэл, тэдний шийдвэр гаргадаг үйл явц, эмзэг болон боломжоор дутмаг бүлгүүдийн хэрэгцээнд тохируулна.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 1, догол мөр 31 (2012): “Нөлөөлөлд өртөх бүлгүүдэд сөрөг нөлөө ихтэй төслүүд дээр Үйлчлүүлэгч нь өмнөх Зөвлөлдөх хэсэг дахь аргачлалууд дээр Мэдээлэл ба Оролцоо бүхий Зөвлөлдөх \МОН\ үйл явцыг нэмэлт болгон хэрэгжүүлнэ... МОН үйл явц нь мэдээлэл ба байр суурийн саналыг дорвитой хэлэлцэх, зохион байгуулалттай, харилцан зөвлөлдөх үйл явц бөгөөд Үйлчлүүлэгч нь төслийн шууд нөлөөнд холбогдох Нөлөөлөлд өртөх бүлгүүдийг саналуудыг өөрийн шийдвэр гаргах явцад тусгах зорилготой.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 1, догол мөр 22 (2006): “Нөлөөлөлд өртөх бүлгүүдэд сөрөг нөлөө ихтэй төслүүд дээр Чөлөөт, Урьдчилсан Мэдээлэл бүхий Зөвлөлдөх болон Мэдээлэл бүхий Оролцоог дэмжсэн үйл явц хэрэгжүүлнэ. Мэдээлэл бүхий Оролцоо гэдэгт зохион байгуулалттай, харилцан зөвлөлдөх үйл явц бөгөөд Үйлчлүүлэгч нь төслийн шууд нөлөөнд холбогдох Нөлөөлөлд өртөх бүлгүүдийг саналуудыг өөрийн шийдвэр гаргах явцад тусгах зорилготой.”

4.4 Төслийн нүүлгэн шилжүүлэх Төлөвлөгөө, түүнд холбогдох нөхөн олговрын гэрээнүүд нь зохисгүй, нөлөөлөлд өртсөн иргэдийн амьжиргааг устгаж байна

¹⁶ <http://ubpost.mongolnews.mn/?p=1442>

¹⁷ IFC, OT LLC Environmental and Social Review Summary, BCS.

2004 онд энэ төслийн лицензтэй газраас 11 өрхийг өвөлжөөнөөс нь шинэ, нөхцөл муутай газруудад хүчээр нүүлгэн шилжүүлсэн болно. Үүнийгээ өмнө дурдсан урьдчилсан, мэдээлэл бүхий, чөлөөт зөвшөөрөл

авалгүй гүйцэтгэсэн байна. Компани 10 өрх шилжүүлсэн гэх боловч нэг өрх хангалтгүй нөхцөлөөс болж хуучин бууцандаа буухад хүрсэн тул энэ тухай мэдээлэх сонирхолгүй Компани тоогоо зассан байна¹⁸.

Компани зам, олон улсын нисэх онгоцны буудал, бусад дэд бүтэц барьж байгуулах ажлаа эхлүүлснээс 8489 өрх \түүний дотор нүүлгэн шилжүүлсэн 7 өрх\ нөлөөлөлд өртөх болж 2010 оноос эхлүүлсэн “нүүлгэн шилжүүлэлтгүй нөхөн олговрын хөтөлбөр”-т хамрагдах эрх нээгдсэн. Шудрага бус гэж нутгийн малчид эсэргүүцэж байгаа энэ гэрээндээ гарын үсэг зуруулах гэж хуурах, сүрдүүлэх, дарамтлах зэрэг бүхий л арга мэхийг Компани хэрэглэж байгаа тухай гомдол¹⁹ байна. БОННУ-нд шинэ гэрээний тухай мэдээлэл байхгүй байгаа нь тэдний шаардлагыг шийдээгүй байна. Компани 2004 оны нүүлгэн шилжүүлэх гэрээг Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнд хавсралтаар нийтэд нээлттэй болгосон атлаа 2011 оны нөхөн олговрын гэрээг ил тод болгохыг Оюу Толгойн Хяналт ТББ-аас удаа дараа шаардсаар байтал нийтэд танилцуулаагүй хэвээр байна.

Нөхөн олговрын гэрээний дутагдал нь малчин өрхийг бичил бизнес гэж үнэлэхгүй зүгээр л нэгэн өрх гэж нөлөөллийг тооцож байгаад оршино. Малчин өрхийн амьжиргаа нь малын бүтээгдэхүүний чанар, түүнд нөлөөлөх худаг ус, хангалттай бэлчээр болон өвөл хөлддөггүй бууц зэрэг дэд бүтцээс шууд хамааралтай байдаг. Доройтсон бууц ба бэлчээр, эвдэрсэн худгийн насос, зудтай өвөл зэрэг сөрөг нөлөөлөл хавсарснаас нэлээд олон өрхийн мал хорогдож, нэг өрх бүрмөсөн малгүй болсон нөлөөлөл бүртгэгдсэн байдаг. Уурхайн ажиллагаанаас газрын хэрэглээнд бий болсон өөрчлөлтөөс малчдын эдийн засгийн доройтол, улмаар амьжиргааны чанар буурч байгааг үл ойшоож болохгүй хэрэг юм.

Энэ асуудлыг жишээлбэл олон улсын нисэх онгоцны буудлыг хувьд ойр орчимд амьдардаг малчдын зууншлагын газарт баригдаж байгаа тул 22-хон өрх нөлөөлөлд өртсөн гэж Газар ашиглалт ба Нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийн үнэлгээ гэсэн хэгэт тодорхойлсон байна.²⁰ Гэтэл нисэх онгоцны буудал барьж буй газар нь Гавлиут, Жавхлант багуудын оторлох газар юм. Энэ газар Ундайн гол ил урсдаг тул хамгийн сайн бэлчээрийн нөхцөлтэй байна. Малчид өрхүүд цаг муу үед энд оторлодог нөөц бэлчээр юм. Нутгийнхны энэ чухал нөөц газар нисэх онгоцны буудал барьж байгаагийн нөлөөлөл нь 11 км урт нисэх зурваснаас хамаагүй өргөн цар хүрээтэй байх юм. Олон улсын нисэх онгоцны буудал байршуулах газрыг дутуу үнэлсэн, түүнээс улбаалан дутуу тооцогдох нөхөн олговрын асуудал нь ноцтой зөрчил бөгөөд даруй засч залруулвал зохих зүйл.

¹⁸ ОТ БОННУ, Бүлэг D10, х 44

¹⁹ Жишээлбэл, нэг малчныд гэрээнд гарын зсэг зуртал нь ОТ ажилтан өдөр бүр ирж шаарддаг байж. Заримд нь гарын үсэг зураагүй ганцаар үлдсэн өрхүүдийг хаяна, бусад өрхүүд нөхөн олговороо авах ажлыг хойш татаж байна, ТББ-ууд эрхийг нь хамгаалж чадахгүй эсвэл ажлын байр, тахир дутуугийн олговор мэт амлах зэргээр худал хэлж зуруулж байсан байна.

²⁰ ОТ БОННУ, Бүлэг C10, х. 15 ³¹ Дээрх гомдлууд даамжирсаар 2012 оны 10 дугаар сард малчид ОУСК-ийн гомдлын механизмд гомдол гаргахад хүргээд байна.

Гомдлыг үндэслэлтэй хэмээн үзэж бүртгэж авсан байна. (see http://www.cao-ombudsman.org/cases/case_detail.aspx?id=191)

Харамсалтай нь 2004, 2011 нөхөн олговрын гэрээнүүдэд эдгээрийг үнэлж тооцоогүй, биет байршлаас шаалтгаалсан физик нөлөөллийг тооцсон байна. Иймд, хүчээр зөвшөөрүүлэх гээд байгаа нөхөн олговор нь малчдад төслөөс учруулсан алдагдлыг нөхөхөд хангалтгүй байна. Дээрх гэрээнүүдэд эрх нь хамгаалагдаагүй тул өөрсдийгөө эртний монголын нүүдэлч соёлыг тээгч уугуул иргэд хэмээн тодорхойлдог малчид хойч үедээ энэ уламжлалт соёлоо өвлүүлэн үлдээх боломжгүй³¹ болж байгаа юм.

Бодлогын зөрчил

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 5, догол мөр 9 (2012): “Нүүлгэн шилжүүлэхээс өөр шийдэл байхгүй тохиолдолд Үйлчлүүлэгч нь байршлаа алдаж буй бүлгүүд эсвэл иргэдэд нүүлгэн шилжүүлэлтийн бүх зардал, амьжиргааны түвшинг дээшлүүлэх эсвэл сэргээхэд чиглэсэн энэхүү Үйл ажиллагааны Стандартад заасан бусад туслалцаа үзүүлнэ. Нөхөн олговрын стандартыг илт тод байлгаж нөлөөлөлд өртсөн бүх бүлгүүд, иргэдэд жигд хэрэглэнэ.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 5, догол мөр 20 (2012): “Байршлаа алдаж буй иргэдийг нүүлгэн шилжүүлэх газрууд нь сайжруулсан нөхцөлтэй байна.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 5, догол мөр 8 (2006): “Нүүлгэн шилжүүлэхээс өөр шийдэл байхгүй тохиолдолд Үйлчлүүлэгч нь байршлаа алдаж буй бүлгүүд эсвэл иргэдэд алдаж буй өмч хөрөнгийг бүрэн гүйцэд нөхөх хэмжээний олговор болон амьжиргааны түвшинг дээшлүүлэх эсвэл ядаж сэргээхэд чиглэсэн энэхүү Үйл ажиллагааны Стандартад заасан бусад туслалцаа үзүүлнэ. Нөхөн олговрын стандартыг илт тод байлгаж төслийн хүрээнд жигд хэрэглэнэ. Нүүлгэн шилжүүлэх иргэдийн амьжиргаа газар ашиглалтаас хамааралтай эсвэл газрыг бүлгээр эзэмших тохиолдолд Үйлчлүүлэгч нь шаардлагатай бол газарт суурилсан нөхөн олговор олгоно. Үйлчлүүлэгч нь нөлөөлөлд өртсөн бүлгүүд, иргэдэд төслийг хүрээнд хөгжлийн үр ашиг хүртэх боломж олгоно.”

Бодлогын зөрчил

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 7, догол мөр 14 (2012): “Нөлөөлөлд өртсөн уугуул иргэдэд нөхөн олговор олгож, тэдний газар ба байгалийн баялгийг арилжааны чиглэлээр ашиглах гэж байгаа бол газар авах хуулийн үйл явц, соёлын хувьд зохимжтой тогтвортой хөгжих боломжууд, түүний дотор:

- Бэлэн мөнгөний оронд газар буюу мөнгөн бус хэлбэрийн нөхөн олговор олгох;
- Байгалийн баялаг хүртэх боломжийг баталгаажуулах, дүйцэх нөөцөөр орлуулах, эсвэл төсөл газар авснаас үл шалтгаалан төслийн үйл ажиллагаанд өртөж байгалийн баялаг ашиглах боломжгүй болсон бол хамгийн эцсийн арга болгон нөхөн олговор олгож өөр амьжиргааны эх үүсвэр олж өгөх;
- Үйлчлүүлэгч нь Нөлөөлөлд өртөх уугуул иргэдийн амьжиргааны эх үүсвэр болох байгалийн баялгийг ашиглаж эрсдэл учруулах тохиолдолд байгалийн баялаг ашигласнаас бий болох үр шимийг тэгш болон шудрага байдлаар хүртээх;
- Эрүүл мэнд, аюулгүй байдалд харшлахгүй бол төслийн ашиглаж байгаа газрыг ашиглах, дамжин өнгөрөх зэргээр Нөлөөлөлд өртөх уугуул иргэдэд нээлттэй байлгах.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 7, догол мөр 13 (2006): Хэрэв Үйлчлэгч нь заншлын эсвэл уламжлалын эзэмшилд байгаа газар дээр төсөл байрлуулах, эсвэл арилжааны хэлбэрээр байгалийн баялаг ашиглах тохиолдолд Уугуул иргэдийн амьжиргаа эсвэл соёл, заншил, шашин шүтлэгийн зан үйлд сөргөөр нөлөөлөх бол дараах арга хэмжээ авах хэлбэрээр тэдний ашиглах эрхийг хүндэтгэнэ... Үйлчлүүлэгч нь Уугуул иргэдийн бүлгүүдийн эзэмшлийн газрыг арилжааны хэлбэрээр ашиглах гэж байгаа бол хамгийн наад зах нь нөхөн олговор олгох болон үндэсний хууль тогтоомжоор газар эзэмших хуулийн эрх авсан этгээдэд нээлттэй хуулийн процедур хэрэглэхийн зэрэгцээ соёл заншлын хувьд зохистой хөгжих боломж олгох; газарт түшиглэсэн нөхөн олговор эсвэл мөнгөн бус нөхөн олговор олгох хэлбэрүүдийг мөнгөн олговороос давуу хэрэглэнэ.”

4.5 БОННУ-нд Жендерийн нөлөөллийн үнэлгээ, хүйсийн ялгавартай дүн шинжилгээ хийгдээгүй байдал

Энэ бүс болон Ханбогд суманд уул уурхай эрчимтэй хөгжиж байгааг харгалзан жендерийн нөлөөллийг үнэлгээнд онцгой анхаарах хандуулах нь зүйтэй байсан юм. Гэтэл, энэ БОННУ-нд асуудлыг судалж үнэлгээ хийсэн хэсэг тусгагдаагүй байна.

АХБ-ны төсөөллөөр Ханбогдын хүн ам 2020 он гэхэд үлэмж хэмжээгээр өсч 3,522²¹ (2010 оны хүн амын тооллогоор)-ээс 2015 онд 14,000, 2020 онд 20,000 хүрэх аж. Уурхайн салбарт ихэвчлэн эрэгтэйчүүд ажилладаг тул ийм хэмжээний өсөлт хүйсийн хувьд томоохон өөрчлөлт дагуулна. БОННУ-нд Оюу Толгойн ажиллах хүчний 30% нь эмэгтэйчүүд бөгөөд өсөх төлөвтэй гэсэн боловч МУ-ын хуулинд уул уурхайн салбарт эмэгтэйчүүдийг ажиллуулахыг хязгаарласан заалтууд байгаа нь дээрх мэдэгдлийг үгүйсгэж байгаа юм.

²¹ Хүн амын тооллого нь зөвхөн бүртгэлтэй иргэдийн тоолдог. Ханбогдын хүн ам бүртгэлгүй оршин суугчдыг оролцуулбал дээр тайлагнасан тооноос хоёр дахин давна

Үүний дээр, биеэ үнэлэх, БЗХӨ-ний өсөлт зэргийг зөвхөн өөрийн ажиллагсдын хүрээнд урьдчилан сэргийлэх, сааруулах бус орон нутгийн хэмжээнд тооцож багтаах нь зохистой. Ажлын байр, ялангуяа ажилчдын кэмп дахь эмэгтэйчүүдийн эсрэг билгийн дарамт ба хүчирхийлэл нь асуудал болсон атал компани нь ажлын байранд хүйсийн дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дүрэм журам гаргаж мөрдүүлэхгүй, аливаа дарамтыг хориглосон ерөнхий ёс зүйн дүрмээр зохицуулж байна.

Нутгийн иргэд мөн урт хугацаагаар үргэжлэдэг уурхайн ажлын ээлж (дунджаар 21-45 хоног) нь гэр бүлийн амьдралд сөргөөр нөлөөлөл байгаа тухай гомдол гаргаж байна. Гэрээс хол өнгөрөөсөн цаг хугацаа гэр бүл салалтын түвшин нэмэгдэхэд нөлөөлж байгаа нь эмэгтэйчүүдэд хамгийн хүндээр тусдаг нөлөөлөл юм.

Бодлогын зөрчил

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 1, догол мөр 31 (2012): “Зөвлөлдөх үйл явцад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алины саналыг багтаах бөгөөд шаардлагатай бол тусгайлан зохион байгуулсан уулзалт хэлэцүүлгээр оролцуулж нөлөөлөл, саруулах механизм, үр ашиг хүртэх зэрэг асуудлаарх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн аль алины байр суурийг тусгана.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 2, догол мөр 15 (2012): “Үйлчлүүлэгч нь дарамт, айлган сүрдүүлэх болон мөлжлөг зэрэг ялангуяа эмэгтэйчүүдийн эсрэг үйлдлээс урьдчилан сэргийлнэ.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 1, догол мөр 12, ишлэл 2 (2006): “Үйлчлүүлэгч нь эмзэг эсвэл боломжоор дутмаг байдлаасаа шалтгаалан нөлөөлөлд илүү эсвэл өөр хэлбэрээр өртөх бүлгүүдийг Үнэлгээний хэсэг болгон тодорхойлж тогтооно. [Ийм байдал нь иргэн эсвэл бүлгүүдийн арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон өөр үзэл бодол, нийгмийн гарал, өмчийн байдал, гарал үүсэл ба бусад байдлыг хэлнэ. Үйлчлүүлэгч нь хүйсийн ялгаа,

яг угсаа, соёл, өвчлөл, биеэ эсвэл сэтгэцийн хөгжлийн бэрхшээл, ядуурал эсвэл эдийн засгийн боломжоор дутмаг эсвэл байгалийн нөөцөөс хараат байдлыг харгалзан үзнэ.”

4.6 Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ нь уурхайн ажиллагаа, тоосноос шалтгаалах нөлөөллийг бүрэн гүйцэд тусгаагүй

БОННУ-нд бүс нутгийн хүн амын эрүүл мэндийн байдлын тухай тусгасан боловч тоосжилтоос хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай. Өмнөговь аймаг уул уурхайг түлхүү хөгжүүлж аймаг бөгөөд тоосжилт, хүн амын огцом өсөлтөөс шалтгаалсан амьсгалын замын өвчлөл хамгийн их хувьтай байгаа тухай Ханбогд сумын эмч 2011 оны 7 дугаар сард судалгаагаар явсан ТББ-дын төлөөлөлд

мэдээлсэн байдаг.²² Энэ байдал нь Өмнөговь аймаг дахь Ухаа худаг уурхайн II шатны БОННУнд тусгасан мэдээлэлтэй дүйж байгаа юм.²³

БОННУ-нд тоосжилт хэмжих 5 цэгийн байршлыг салхины давамгайлах нөхцөл болон нөлөө өндөр байх магадлалыг харгалзан сонгосон гэжээ.²⁴ Гэтэл тоос хэмжих баримтын хуудаст тоосжилтын ердийн хэмжилтийг 2003 оноос хойш 7 цэгт хэрэгжүүлж ирсэн тухай өгүүлсэн байна.²⁵ Гэтэл эдгээрийн ганц нь ч Ханбогд сумыг чиглэсэн хэмжилт хийдэггүй байгаа нь ноцтой дутагдалтай байна. 2011 оны 7 дугаар сард ТББ-ын тогтоосноор Ханбогд сумын захиргаанд тоосжилтыг хэмжиж хянах мэргэжлийн болон санхүүгийн чадатж байхгүй тул ийм төхөөрөмжүүд суулгахад туслалцаа үзүүлэх шаардлагатай³⁷.

Нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх хэсгүүдэд орхиж дутагдуулсан асуудлууд олон байна. БОННУ-нд уурхайн нойтон хаягдал байгаль орчин ба хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх дурдаагүй бөгөөд агаарт уурших хийн бохирдлоос хүн ам, малын эрүүл мэндэд нөлөөлөл ямар байхыг мөн л тусгаагүй байна. БОННУ-нд үйлдвэрлэлийг зогсоох, уурхайн хаалтын ажиллагаанаас эрүүл мэнд, аюулгүй байдал учрах нөлөөллийг дурдсан боловч,²⁶ уурхайн хаалтын төлөвлөгөө байхгүй тул эдгээр эрсдлийг хэрхэн сааруулах эсвэл сааруулах эсэх нь тодорхойгүй байна.

Бодлогын зөрчил

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 4, догол мөр 8 (2012): “Төслөөс байгалийн нэн хэрэгцээт нөөцөд учруулах шууд нөлөө нь Нөлөөлөлд өртөх бүлгүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг эрсдүүлэхэд хүргэдэг.. Цэнгэг усны чанар, тоо хэмжээ, хүртээмж зэрэг байгалийн нөөцийн доройтол хомсдол нь эрүүл мэндийн эрсдэл дагуулдаг. Шаардлагатай бол Үйлчлүүлэгч нь уур амьсгалын өөрчлөлтөөс улам даамжрах экосистемийн нөөцөд учирч болзошгүй эрсдлүүд, нөлөөллийг тогтооно. Сөрөг нөлөөлөл учруулахаас зайлсхийх шаардлагатай бөгөөд зайлсхийх боломжгүй бол Үйлчлүүлэгч нь Үйл ажиллагааны Стандартын 6-ийн 24 ба 25-д заасан сөрөг нөлөөлөл сааруулах арга хэмжээ авна.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 4, догол мөр 9 (2006): “Үйлчлүүлэгч нь мөн нутгийн иргэдийн хэрэглээнд буй хөрс, ус болон бусад байгалийн нөөцөд сөрөг нөлөө учруулахаас зайлсхийх, нөлөөллийг саруулах арга хэмжээ авна.”

²² CEE Bankwatch Network, BIC, urgewald. 2011. *Spirited away: Mongolian Mining Boom and the People that development left behind.* <http://bankwatch.org/sites/default/files/spirited-away-mongolia-mining.pdf>

²³ <http://www.energyresources.mn/uploads/14649Hrpt - ESIAfinal.pdf>

²⁴ ОТ БОНН, Бүлэг В3, х 8

²⁵ http://www.ot.mn/sites/default/files/documents/ESIA_Factsheet_Dust_EN.pdf ³⁷ See

CEE Bankwatch, et al.

²⁶ ОТ БОННУ, Бүлэг С12, х 6

5. Усны нөөцийн менежмент

Монгол улс усны нөөц багатай, ялангуяа Оюу толгой төсөл орших Өмнөговьд бүр хязгаарлагдмал нөөцтэй улс. Энэхүү хязгаарлагдмал нөөц нь уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, энэ бүсэд өрсөлдөх олон уурхайн төслийн үйлчлэлээр улам хомс, хүртээмжгүй болох магадлалтай. Иймд Оюу Толгой төсөл хэрэгжих нийт хугацааг хамарсан усны менежментийн нарийвчилсан, бүх талуудыг, түүний дотор шууд, шууд бус, хуримтлагдах болон хам нөлөөг тооцсон, эдгээрийн байгаль орчин ба хүн амд нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулах болон саруулах төлөвлөгөө боловсруулах учиртай. Хэлэлцүүлж буй БОННУ-нд усны нөөцийн менежментийн төлөвлөгөөнд зөвхөн барилгын шатны үйл ажиллагааг багтааж, үйлдвэрлэл болон хамаарах бусад байгууламжуудын хэрэглээг тооцож оруулаагүй тул нөлөөлөл ба эрсдлүүдийг хангалттай тусгаагүй байна. Энэ мэдээлэл хуримтлагдах нөлөөллийн хэсэгт ч багтаагүй байна.

5.1. БОННУ-нд Гүний Хоолойн усыг ашиглах нь хөрсний болон бусад усны нөөцөд нөлөөлөхгүй гэдгийг тогтоогоогүй

Аливаа том уурхайн адил, Оюу Толгой төсөлд барилгын болон үйлдвэрлэлийн шатны үйл ажиллагаанд асар их хэмжээний усны нөөц шаардагдана. Энэ тохиолдолд, Компани өөрийн хэрэгцээний усны дийлэнхийг Гүний Хоолойн эртний усны нөөцөөс авна гэж мэдэгдэж байгаа. БОННУ-нд Гүний Хоолойн усыг хэрэглэх тухай дараах байдлаар тусгасан байна:

Оюу Толгой МУ-ын Засгийн газраас өдөрт 70,000 м³ усыг Гүний Хоолойн нөөцөөс татах зөвшөөрөлтэй. МУ-ын эдийн засагт эерэг нөлөө өндөр байх тул (Төсөл эхлэх цагт ДНБ 30-40% өснө), эдийн засгийн өндөр өсөлтийн төлөө Гүний Хоолой дахь эртний усны нөөцийг ашиглах нь хангалттай үндэслэл; гэхдээ усыг хэрэглэх явцад хариуцлагатай хандаж зарцуулсан усны нэгжид ноогдох ашгийг өндөр байлгах шаардлагатай. Гүний Хоолойн усны хэрэглээний загварт Оюу Толгой төсөл 40 жилийн хугацаанд усны түвшинийг хадгалах байдлаар ашиглаж болох зураг харагдаж байна.²⁷

Гүний Хоолойн усыг ашиглах Компанийн төлөвлөгөөнд нэлээд хэдэн дутагдал байгааг дор толилуулаж байна.

Нэгдүгээрт, 2020 оноос хойш буюу уурхайн үйлдвэрлэл үргэлжлэх 27 жилийн хагаст ч хүрэхгүй хугацаанд Гүний Хоолойн нөөцөөс уурхайн төслийн бүх хэрэгцээг хангаж чадах, ингэхдээ ойр орчмын усны нөөцөд

нөлөөлөхгүй гэдгийг нотолж чадаагүй байна. Иймд гүний усыг ашигласнаар бусад давхрагын усанд сөрөг нөлөө учрахгүй гэсэн баталгаа алга байна. Шаварлаг давхрага нь уст давхрагуудын хооронд битүү үргэлжилсэн байх баталгаа байхгүй болон цооног тавих явцад цав, хагарал үүсч шүүрэл явагдах магадлалтай. Нэг цоногийн хувьд энэ үйл явц бодит байдлаар явагдаж байгаа бололтой.²⁸ Малчдын ярьж байгаагаар 2012 оны 6 дугаар сард Солонгосын судлаачид ирж дахин 4 цооногт ус доош алдагдаж байгааг тогтоосон, Компани түүнигээ хүлээсэн гэдэг. Малчид судалгааны багтай хамт явсан, зарим нь Усны газар очиж видео бичлэг үзсэн боловч харамсалтай нь энэ судалгааны тайланг нийтэд нээлттэй болгоогүй байна.

²⁷ ОТ БОННУ, Бүлэг С5, х 4

²⁸ Мөн тэнд, х 29

Ус татснаас үүсэх хөрсний суулт болон ус нөхөгдөх урт хугацаа нь усны түвшин буурахад хүргэж усны нөөцийг бүрмөсөн шавхах магадлал бий. Гэтэл гүний усны нөөц бусад давхрагын хооронд усны солилцоо байхгүй гэсэн Компанийн мэдэгдлийг батлах нийтэд нээлттэй нотолгоо байхгүй байсаар атал үүний давтсаар байна.²⁹ Мөн төсөл өдөрт 160,000 тон хүдэр боловсруулах бол усны хэрэглээ нэмэгдэх бөгөөд Гүний Хоолой, бусад усны нөөцөд нөлөө бий болох тухай тусгаагүй байна.

Хоёрдугаарт, ус хувьчлалтай холбоотой үүсч болох улс төрийн асуудал байна. Оюу Толгой төслийн хэрэгцээг хангах зорилгод хөтлөгдөн Монголын Засгийн газар Усны тухай хуулиа өөрчилж Компанид хайгуул хийж олсон усаа захиран зарцуулах бүрэн эрх олгосон байна. Компани нь Гүний Хоолойн нөөцөөс ус татах хэмжээгээ батлуулах боловч тухай усны нөөцийн өмчлөгч нь юм. Нутгийн иргэд Гүний хоолойн усны суваг барих ажлыг хүчтэй эсэргүүцсэн боловч усыг хувьд ашиглуулах хуулийн заалтын улмаас тэдний гомдлыг үл ойшоож ирсэн. Энэ хуулиар нутгийн иргэдийн усны эрхээ хамгаалах маргааныг шийдэх боломжийг Засгийн газар нь том олборлох компаниудын эрх ашигт нийцүүлэн шийдсэн байна. Өөрийн өмчийн ус ашиглалтаас бусдын өмчийн усны нөөцөд нөлөөлөхгүйг батлаагүй байгаагийн учрыг ойлгоход дөхөм болох зорилготой дээрх мэдээллийг өгч байгаа болно.

5.2. Ундайн голын голдирлыг өөрчлөх Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг даруй нийтэд мэдээлэх шаардлага

Ундайн гол нь Ханбогд сумын хүн ам, ан амьтан, байгалийг усаар тэтгэдэг цорын ганц гадаргын усны нөөц бөгөөд Оюу Толгой төслийн лицензтэй талбай дундуур урсдаг говийн шургадаг гол юм. Ундайн голын урсгал дотор ил уурхайн барилгын ажил явагдаж байгаа тул Компани нь голын голдирлыг ханаар хааж газар доорх сувагаар голдирлыг өөрчилж урсгахаар төлөвлөж байна. Голын 6.8 км урт хэсэг, түүний дотор энэ бүсэд чухал үүрэг бүхий гадаргын ус болох Бор Овоо дахь булаг алдагдах юм.³⁰ Бор Овоод энэ булгийн гүйцэтгэх байсан экосистемийн үйлчилгээг нөхөх зоригоор Компани хиймэл булаг байгуулахаар төлөвлөж байгаа гэх боловч БОННУ-нд энэ тухай тодорхой мэдээлэл алга. Харин ч БОННУ-нд Ундайн голын голдирлыг өөрчлөх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний зарим хэсгийг Засгийн газар батлаагүй байгаа тул мэдээллийг тусгаагүй гэдгээ хүлээсэн байна.³¹

Энэ нарийвчилсан үнэлгээ нь 2012 оны сүүлчээр бэлэн болж барилгын ажил нь 2013 буюу зөвшөөрлүүдийг авмагц эхэлнэ гэсэн боловч энэ нь үйлдвэрлэл 2012 оны сүүлчээр эхэлнэ гэсэн мэдэгдэлтэй зөрчилдөж

байна.³² Хэрэв ил уурхайд хэдхэн сарын дараа хүдэр олборлох ажил эхлэх гэж байгаа уурхай руу ус урсаж байж таарахгүй тул голын голдирлыг олборлолт эхлэхээс өмнө өөрчлөх хэрэг гарна. Төрийн холбогдох байгууллагуудын зөвшөөрөлгүйгээр голдирлыг өөрчлөх барилгын ажил эхэлхэн тухай мэдээлэл байдаг. Бид

²⁹ Johnston, L. 2011. *Mongolia – Oyu Tolgoi Copper/Gold/Silver Mine Project Trip Report*. USAID, p 8
<http://mongolia.usaid.gov/wpcontent/uploads/Mongolia-Oyu-Tolgoi-Trip-Report.pdf>

³⁰ ОТ БОННУ, Бүлэг С5, х 8

³¹ Мөн тэнд, х 22

³² ОТ БОННУ, Бүлэг А5, х 8: “Нарийвчилсан инженерийн дизайн 2011 онд бэлэн болсон. 2013 онд холбогдох монголын талын зөвшөөрлүүдийг авмагц барилгын ажил эхлүүлнэ.”

хэд хэдэн удаа нарийвчилсан үнэлгээний тайланг авах хүсэлт тавьсан ч мэдээлэл авч чадаагүй болно. Уурхайн үйлдвэрлэл эхлэхэд чухал ач холбогдолтой төсөл тул нарийвчилсан үнэлгээг БОННУ-тний хамт хэлэлцүүлэх чөтөй юм. Ингэж орхигдуулсан нь хүлээн зөвшөөрч болохгүй үйлдэл бөгөөд нарийвчилсан үнэлгээг бүх талууд болон мэргэжлийн багуудаар хэлэцүүлж батлуулсны дараа аливаа санхүүжилтийн асуудал шийдэгдэх учиртай.

5.3. Уурхайн хаягдлыг хуурай хэлбэрээр хадгалахын оронд нойтон хаягдал хадгалахаар шийдвэрлэсэн нь байгаль орчин ба нийгмийн гамшигийн эрсдлийг асар их хэмжээгээр нэмэгдүүлжээ

Дэлхий дахины байгаль орчны хуулийн альянс (ELAW)-ын үнэлснээр, уурхайн хаягдлыг усгүйжүүлээд эргүүлж уурхайн нүх хонгилд шахах хуурай хаягдын технологи нь байгаль орчинд хамгийн ээлтэй гэж үздэг.³³ Хуурай хаягдал нь хаягдалд агуулагдах усны хэмжээг багасгаж хаягдлын даланд хүчиллэг шүүрэл үүсэх явцыг багасгадаг. Энэ нь компанийн хаягдлын далангийн ажиллагаанд хэрэглэх усны хэмжээг багасгаад зогсохгүй гадаргын болон гүний усыг бохирдлоос хамгаалдаг. Зуурмагийг уурхайн хаалтын үед ил ба далд уурхайн ухагдсан орчныг дүүргэх, өмнөх байдалд түргэн оруулах зорилгоор хэрэглэж болдог давуу талтай.

Компани нь харин уурхайн хаягдлыг нойтон хадгалдаг ердийн технологийг сонгохдоо эрс хүйтэн өвлийн нөхцөлд зуурмаг хөлдөж ажил зогсох эрсдэл дагуулах тул сонгоогүй гэсэн үндэслэл бичжээ.⁴⁶ ELAW-ийн тайлбарласнаар “хүйтэн ба хуурай нөхцөлд хуурай хаягдал хэлбэрийг ашиглах нь бусад технологиос хамгийн оновчтой” дээрх үндэслэл нь оргүй байна.”³⁴ Жишээлбэл, жилийн дундаж агаарын температур нь хамгийн дулаан цагт +20С, -53С хүрч хүйтэрдэг Канадын Нунавут мужид өвөл хөлддөг тул хамгийн зохимжтой технологид тооцогддог.³⁵ Энэ технологийг хэрэглэхгүй байхыг ганц шалтгаан нь эхлэх хөрөнгө оруулалтын зардал боловч нойтон хягдал хадгалах бохирдол, түүнээс үүсэх эрсдэлтэй харьцуулахад өчүүхэн зүйл юм.

Оюу Толгойн төслийн усны алдагдлын 80% нь нойтон хаягдлын далангийн ажиллагаатай ³⁶ холбоотой тул байгаль орчинд илүү ээлтэй, усанд хэмнэлттэй технологийг сонгоогүй нь туйлын ойлгомжгүй юм. Харамсалтай нь БОННУ-нд дурдсан хоёр үндэслэл баримт бичгүүд нь нийтэд нээлттэй бус тул Компанийн ердийн нойтон хаягдлын технологи ашиглах шийдвэрт хөндлөнгийн үнэлгээ хийх боломжгүй байна.³⁷ Ийнхүү уурхайн үндсэн үйлдвэрлэлийн ажиллагаанд холбогдох, ялангуяа хуурай бүсийн усны нөөц, чанарт нөлөөлөх мэдээлэл ил тод бус байгаа нь хүлээн зөвшөөрч болохгүй байдал юм.

³³ Environmental Law Alliance Worldwide (ELAW). 2010. Уурхайн төслийн БОННУ-г нягтлах удирдамж, р 29 <http://www.elaw.org/mining-cia-guidebook> ⁴⁶ OT ESIA, Chapter A5, p 28

³⁴ See attached: Chernaik, M. and H. Weiskel. 2012. Оюу Толгой төслийн БОННУ-ийн нягтлал. ELAW, x 3

³⁵ Ibid, p 4

³⁶ OT БОННУ, Бүлэг C5, x 55

³⁷ Chernaik and Weiskel, p 3

Бодлогын зөрчил

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 3, догол мөр 9 (2012): “Төсөл нь их хэмжээний ус хэрэглэх магадлалтай тохиолдолд Үйл ажиллагааны Стандартын нөөцийн үр ашигтай хэрэглээний шаардлагад нийцүүлэхээс гадна Үйлчлүүлэгч нь төслийн усны хэрэглээнээс бусдад улэмж сөрөг нөлөө үзүүлэхгүй байхыг зорьж усны хэрэглэхээс зайлсхийх эсвэл хэрэглээг багасгах арга хэмжээ авна.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 3, догол мөр 6 (2012): “Үйлчлүүлэгч нь бизнесийн үйл ажиллагааныхаа үндсэн үйл ажиллагаанд хэрэглэх эрчим хүч, ус болон бусад нөөц материалын үр ашигтай зарцуулалтыг сайжруулах, өртөг зардыг хувьд оновчтой технологи болон санхүүгийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэнэ.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 3, догол мөр 4 (2006): “Үйлчлүүлэгч нь бохирдуулагч бодисыг хаях, хаягдлаас зайлсхийх өөр арга байхгүй бол хаягдлын бохирдуулах түвшин арга хэмжээ авна. Энэ нь орон нутаг, тухай бүс нутаг болон хил дамнасан нөлөөлөл бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус болон ослын хаягдал бүгдэд хамаарна. Үүний зэрэгцээ, Үйлчлүүлэгч нь цэвэр үйлдвэрлэлийн зарчимд нийцүүлэн нөөцийг хэмнэлттэй ашиглах, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх арга хэлбэрүүдийг судалж нэвтрүүлэнэ.”

6. Байгалийн төрөл зүйл

Байгалийн нөөц баялаг, хүний хэрэглэдэг нөөцгийг тэтгэж байдаг байгалийн төрөл зүйлийг олон улсын хэмжээнд тогтоосон стандартад нийцүүлэн хамгаалах нь аливаа төслийн эн тэргүүний үүрэг байдаг.³⁸ Өмнөговийн нутаг нь дэлхийд өөр хаана ч байдаггүй, устах эрсдэлд орсон 6 төрөл зүйлийн нутаглах газар юм.³⁹ Хоёр хамгаалалттай газар, Их Говийн ТХГ, Бага Говийн ТХГ Оюу Толгой төсөлд ойрхон орших бөгөөд төслийн нөлөөллийн бүсэд багтдаг юм. Ялангуяа Бага Говийн ТХГ нутаг дэвсгэрт зам харгуй тавидаж, цаашид Оюу Толгой болон бусад уурхайгаас Гашуун Сухайтын боомт руу эрдэс баялаг зөөх төмөр зам ч тавигдаж болзошгүй байгаа. Уурхайгаас ан амьтдын нутаглах чухал газруудад сөрөг нөлөөлөл бий болох тул БОННУ-нд бүх талыг хамарсан байгалийн төрөл зүйлийг хамгаалахад чиглэсэн стратеги төлөвлөгөө багтсан байх ёстой. Гэтэл ЕСБХБ “Үйл ажиллагаанд тавих шаардлага” бодлогын баримт бичгийн Шаардалага 1 ба 6-р заалтуудаа түдгэлзүүлсэн нь Хятадаас татсан өндөр хүчидлийн шугам тавихдаа “Байгалийн төрөл зүйлд нөлөөлөх нөлөөг сааруулах журам”-ыг энэ төслийн хувьд хэрэгжүүлээгүйг илтгэж байна.⁴⁰ Энэхүү шаардлагыг хөрөнгө оруулагч олон улсын санхүүгийн байгууллагууд бүгд нэгэн адил шаарддаг юм.

6.1. Суурь үнэлгээг шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд тулгуурлаагүй байдал

³⁸ ОУСК-ийн ҮАС 6 (2012), догол мөр 3

³⁹ See Johnston (USAID) for more info, particularly pp 4-8.

⁴⁰ ЕСБХБ, Оюу Толгой төслийн хураангуй <http://www.ebrd.com/english/pages/project/psd/2012/41158.shtml> ⁵⁴

Төслөөс учруулж болзошгүй нөлөөллийг тогтоохын нэгэн чухал хэсэг нь суурь үнэлгээг хангалттай хийгдсэн байхад оршдог. Оюу Толгойн төслийн БОННУ-ний хувьд “Байгалийн төрөл зүйлийн үнэлгээ” нь бүрэн гүйцэд бус бөгөөд олон улсын стандартад нийцэхгүй байна.⁴⁴ Мэргэжлийн үнэлгээгээр “хязгаарлагдмал мэдээллээс авсан баримтад үндэслэсэн тайлбар танилцуулга хийх стратеги баримталсан” бөгөөд 4-н судалгаа хавсаргасаны нэг нь туршилтад үндэслээгүй цэвэр ажиглалтын судалгаа байна. ⁴¹ БОННУ нь Их ба Бага Говийн ТХГ-т нийлээд 1,400 10x10м талбай хэсгүүдэд амьтан ба ургамал судлах ажил гүйцэтгэсэн гэх боловч энэ нь нөлөөлөлд өртөх газар нутгийн 1%-д ч хүрэхгүй байгаа нь хангалттай загвар жишээ болж чадахгүй байна.⁴²

БОННУ-нд байгаль хамгаалахын чухал хэсэг болох мета популяцийн динамик (нэг амьтан популяци болон нутаглах газруудын хооронд нүүдэллэх)-ийн мэдээллийг багтаагаагүй байна. “Амьтны омгийн одоогийн хөдөлгөөнгүй байдлыг харуулах нь эдгээр амьтдын эмзэг тогтвортой байдлыг харуулахгүй” бөгөөд ийм мэдээлэлд үндэслэсэн менежментийн стратеги нь дутагдалтай байна.⁴³ Говийн экосистемийг нөхөн сэргээх нь хамгийн амаргүй ажил тул зөв тогтоосон суурь үнэлгээгүйгээр төслийн нөлөөллийн бүсэд ямар хэмжээний нөлөөлөл явагдаж байгааг тогтоох арга байхгүй юм.

6.2. Менежментийн төлөвлөгөөн нь бодит бус, тодорхой бус

БОННУ-нд байгалийн төрөл зүйлд учрах сөрөг нөлөөллийг саруулахад хангалттай байгалийн төрөл зүйлийн мониторингийн систем тогтоосон гэх боловч тодорхой мэдээлэл оруулаагүй байгаа нь учир дутагдалтай байна.⁴⁴ Жишээлбэл, БОННУ-нд сайжруулсан бэлчээрийн менежментийн тухай олон удаа дурдсан байх боловч менежментийн төлөвлөгөөнд чухам ямар үйл ажиллагаа багтаж байгаа тухай мэдээлэл өгөгдөөгүй тул энэ менежмент нь бодит байдалд менежментийг сайжруулах эсэхийг дүгнэх боломж алга.⁴⁵ “Ургамал ба амьтны \уржлийн?\ менежментийн төлөвлөгөө”-нд тусгагдсан нөлөөлөл сааруулах аргачлууд нь эсвэл хэт хийсвэр эсвэл бүр зохисгүй байгаа нь дутагдалтай байна. Жишээлбэл, “практик алхмууд” гэгч нөлөөлөл бууруулах төлөвлөгөөнд байгалийн болон соёлын ямар зүйлд хэрэглэгдэхийг тодорхойлоогүй байна.

Тухайлбал ELAW-ийн судлаачдын дүгнэснээр ус хамгаалах төлөвлөгөөнд байгалийн төрөл зүйлд холбогдох түгшүүртэй асуудлууд байна. Ундайн голын голдирлыг өөрчлөх нь төсөл хэрэгжих болон усны адагт орших хэд хэдэн нутаглах газруудад сөргөөр нөлөөлөх бөгөөд газар доорхи урсгалын голдирлыг амжилттай өөрчлөх магадлалтай мэдээлэл алга. Голын голдирлыг өөрчлөхөд ан амьтны усны нөөц болох Бор Овоо дахь булаг ширгэх юм. Компани нь Бор Овоо дахь булгийн экологийн үйлчилгээг дуурайлган хийсэн хиймэл булаг байгуулахаар төлөвлөж байгаа гэх боловч энэ нь одоогийн булгийн үйлчилгээг орлож чадах байгууламж экологийн хувьд боломжтой гэдэг нь төсөөлөгдөхгүй байна.”⁴⁶

⁴¹ See attached: Song, D. 2012. ОТ БОННУ-ийн Суурь Үнэлгээ – Бүлэг В7а-ийн нягтлал: Байгалийн төрөл зүйл. University of Pennsylvania, p 3

⁴² Ibid, p 2

⁴³ Ibid, p 4

⁴⁴ Ibid, pp 5-6

⁴⁵ Chernaik and Weiskel, p 20

⁴⁶ Chernaik and Weiskel, p 18

Нөлөөлөл саруулах стратериудыг хоосон тунхаглал биш харин маш тодорхой тогтоосон аргачлалд суурилсан гүнзгий судалгаанд үндэслэн боловсруулдаг. БОННУ-нд Компанийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бодитой, үнэмшилтэй алхмууд тусгагдаагүй байгааг хүлээн авч боломгүй байна.

6.3. Дүйцүүлэн хамгаалах стратеги нь хангалтгүй, алдаатай баримтад тулгуурласан байна

Дүйцүүлэлт эсвэл хэмжигдэхүйц хамгаалалтын үр дүн гэх хэлбэрүүдийг байгалийн төрөл зүйлийг хамгаалахад нөлөөллөөс зайлсхийх, бууруулах болон нөхөн сэргээх арга хэмжээг хэрэглэсэн ч сөрөг нөлөө байсаар байгаа нөхцөлд ихэвчлэн эцсийн арга хэмжээ болгон хэрэглэдэг. Нэн чухал нутаглах газруудын хувьд дүйцүүлэх арга хэмжээ хэрэгжүлснээр байгалийн төрөл зүйл бүрэн хамгаалагдах учиртай. Гэхдээ, дүйцүүлэлтийн амжилт нь дүйцүүлэлтийн тооцоо хийхэд ашигласан тоо баримтын чанараас шалтгаална. Энэ БОННУ-нд хэрэглэсэн тоо баримт нь их сайндаа л ярьвигтай байгаа нь хөрөнгө оруулагчдын анхаарвал зохих зүйл болно.

БОННУ-ний хамгийн дутагдалтай хэсэг нь дүйцүүлэхэд ашиглах суурь судалгааны мэдээлэл хангалтгүй байгаад оршиж байна. БОННУ-нд зарим экосистемийн үйлчилгээ, мөн биологийн төрөл зүйл дүйцүүлэх боломжгүй алдагдана гэсэн байна гэж биологич Даниэль Сонг тэмдэглээд дараах тайлбарыг хийсэн байна:

БОННУ-нд тусгаснаар байгалийн төрөл зүйлийн алдагдлуудыг дүйцүүлэх боломжтой эсэхийг алдагдал бий болсны дараа мэдэх цорын ганц арга байна гэж. Дүйцүүлэх боломжгүй гэж тогтоогдсон бол үнэхээр дүйцүүлэх боломжгүй байх юм гэдгийг энэ тайланг уншиж байгаа хэн бүхэнд ойлгомжтой байна.⁴⁷

Үнэлгээний гол утга учир нь үйл ажиллагаа эхлэхээс өмнө дүйцүүлэх боломжтой эсэхийг тогтооход оршдог. Хэрэв энэ нөхцөл байдлыг хохирол учирсны дараа тогтоохоос өөр аргагүй гэж байгаа бол энэ үнэлгээний стратегид ноцтой учир дутагдал байгаагийн илэрхийлэл юм.

ELAW-гийн мэргэжилтний тэмдэглэснээр дүйдүүлэлтийн тооцоо нь бас алдаа мадагтай, нэгбүрчлэн хянавал бодит тоо баримт бус харин судлаачийн бодол эсвэл таамагт үндэслэсэн хангалтгүй тооцоо байна⁴⁸. Тавлиц

⁴⁷ Ibid, p 6

⁴⁸ Chernaik and Weiskel, p 19, quoting OT ESIA Biodiversity Appendix 5, p 16 ⁶³ OT ESIA, Biodiversity Appendix 4, p 7

2-т “Билогийн төрөл зүйлийн дүүцүүлэх стратеги” –д жишээлбэл нийт дүйцүүлэлтийн үр дүн нь хөхтөн амтан (551), шувууны (21) төрлөөс үл шалтгаалан ижил байхаад тооцжээ.⁶³

Table 2. Projected net position in 2036 for priority biodiversity features addressed by the offsets strategy (Quality Hectares)

Name	Direct & indirect habitat loss (1000 ha)	Quality of habitat lost (0-1)	Loss from increased hunting (1000 QH)	Residual loss (1000 QH)	Gain from hunting control (1000 QH)	Gain from rangeland management (1000 QH)	Predicted overall offset gain (1000 QH)	Net position (1000 QH)	NPI?
Mongolian Chesney ¹	9	0.9		8	0	21	21	13	Yes
Asiatic Wild Ass	155	0.5	392	470	530	21	551	59	Yes
Argali	30	0.5	392	407	530	21	551	122	Yes
Goitered Gazelle	130	0.5	392	458	530	21	551	72	Yes
Mongolian Gazelle	76	0.5	392	431	530	21	551	99	Yes
Swan Goose	0			0	0	0	0		Yes ²
Ferruginous Duck	0			0	0	0	0		Yes ²
Short-toed Snake-eagle	9	0.9		8	0	21	21	13	Yes ²
Saker Falcon	9	0.9		8	0	21	21	13	Yes ²
Egyptian Vulture	9	0.9		8	0	21	21	13	Yes ²
Great Bustard	71	0.9		64	0	21	21	-43	No ^{2,3}
Houbara Bustard	71	0.9		64	0	21	21	-43	No ^{2,3}
Relict Gull	0			0	0	0	0		Yes ³
Pallas' Sandgrouse	9	0.9		8	0	21	21	13	Yes ²
Yellow-breasted Bunting	9	0.9		8	0	21	21	13	Yes
Mongolian Ground-Jay	9	0.9		8	0	21	21	13	Yes
Granite Outcrop Floral Communities ⁴	0			0	0	0	0	0	Yes
Riverine Elm Trees	0			0	0	+	+	+	Yes ⁵
Tall Saxaul Forest	+	?	-	+	+	+	+	+	Yes ⁶
Eastern Gobi desert-steppe	5.5	0.9		5	0	9	9	4	Yes
Alashan Plateau semi-desert	3.5	0.9		3	0	12	12	9	Yes

¹ Assumed here to represent all 18 'very rare' plants known or predicted from the project area

² Assuming mitigation is put in place on all OT powerlines plus an additional >64km of non-OT powerlines

³ Yes if there is an appropriate additional offset

⁴ Even though these are not predicted to be impacted, they are included here since they are a Critical Habitat-qualifying biodiversity value in the area

⁵ Yes if the three translocated trees survive; offset gains depend on specific offset site

⁶ Yes assuming adequate control of illegal collecting (not quantified)

Нөлөөллийн бүс дэх бүх төрөл зүйл төслийн нөлөөлөлд нэгэн ижил байдлаар хариу реакц өгнө гэж төсөөлсөн нь зүйл амьтад нөлөөллийн бүсэд өөр өөр байдлаар нутаглах бөгөөд нүүдэллэх хэлбэр нь тухайн зүйл амьтан бүрт яаж нөлөөлснөөс шаалтгалдаг гэдгийг тооцоогүй байна.”⁴⁹ Таблиц 2-т багтаасан 4 зүйлийн хөхтөн амьтны нийт тоо нь хүртэл барихгүй байна. Дүн шинжилгээ нь хөдөлгөөнгүй статик суурь мэдээлэлд үндэслэсэн тул Өмнөговийн энэхүү бүсэд явагдах хөгжлийг акселерацгүй буюу төслийн хөгжлийн эхний үеийн нөлөө жигд үргэлжлэхээр тооцоолсон нь бодит бус бөгөөд аюултай дутагдал юм..⁵⁰ Төслөөс санал болгож буй дүйцүүлэх стратеги боловсруулахад шинжлэх ухааны үндэслэл багаатай тоо баримта дүндэслэж байгаа нь үнэлгээний зорилго ба үйл явцыг үгүйсгэж тэр утгаараа энэ төслийг барьж байгуулах, үйлдвэрлэл явуулах үндэслэл болж чадахгүй байна.

Бодлогын зөрчил

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 6, догол мөр 17 (2012): Төслийн нөлөөллийн бүсэд ан амьтны чухал нутаглах газрууд багтах тохиолдолд Үйлчлүүлэгч нь үйл ажиллагаагаа тодорхой шалгууруудад, түүний дотор “чухал нутаглах газарт амьдардаг үнэт биологийн төрөл зүйлд болон тэдгээр төрөл зүйлийг тэтгэдэг экологийн үйл явцуудад хэмжигдэхүйц сөрөг нөлөөлөл үзүүлээгүй байх” мөн and “Үйлчлүүлэгчийн менежментийн хөтөлбөрт бүрэн гүйцэд, зохистой дизайн бүхий урт хугацаанд байгалийн төрөл зүйлийн мониторинг, үнэлгээ хийх хөтөлбөр багтсан байх шаардлагуудад нийцүүлнэ..”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 6, догол мөр 19 (2012): “Нөлөөллийг саруулах стратегийн хэсэг болгон дүйцүүлэх хөтөлбөр санал болгож буй тохиолдолд Үйлчлүүлэгч нь энэ Стандартын 17-д заасан шаардлагыг биелүүлсэн байхын тулд үнэлээ хийх замаар байгалийн төрөл зүйлд төслөөс үлдэх үлэмж нөлөөллийг хангалттай бууруулж чадах төлөвлөгөөгөө харуулна.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 6, догол мөр 9 (2006): Доорх шаардлагыг биелүүлээгүй бол Байгалийн төрөл зүйлийн нутаглах чухал газарт Үйлчлүүлэгч ч ямар ч үйл ажиллагаа эрхлэхгүй:

- Энэ Стандартын 9-д заасан Нутаглах чухал газруудад нь амьтны зүйлийн омгийн хэрэгцээг хангах чадавч болон тухай нутаглах газрыг тэтгэдэг экологийн функцид хэмжигдэхүйц сөрөг нөлөө учруулаагүй
- Устах аюулд орсон эсвэл ховордсон амьтны зүйлийн популяц хорогдоогүй
- Энэ Стандартын 8-д заасан шаардлагад нийцүүлэн бусад бага нөлөөллийн сааруулна ”

7. Дэд бүтэц болон төслийн бусад байгууламжууд

Оюу Толгой мэт том төслүүд амжилттай хэрэгжихийн тулд төмөр зам, авто зам, эрчим хүчний эх үүсвэр, агуулах, ус цэвэршүүлэх г.м. бусад дэд бүтцийн хэрэгцээ байдаг. Эдгээр “хамаарах байгууламжууд” гэж нэрлэгддэг бие даасан дэд бүтцийн төслүүд нь зөвхөн тухайн төслийн хэрэгцээг хангах зорилгоор бий болдог. Иймд эдгээрийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг нийт төслийн нөлөөллийг тогтоох үнэлгээнд тооцож оруулдаг учиртай. Оюу Толгой эдгээрийн заримыг төслийн танилцуулгад дурдсан боловч

⁴⁹ Chernaik and Weiskel, p 20

⁵⁰ OT ESIA ,Biodiversity Appendix 4, p 7

(зам, олон улсын нисэх онгоцны буудал, дамжуулах шугамууд, нүүрсээр галлах цахилгаан станц г.м.), эдгээрт холбогдох байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнүүд нь зохих нарийвчлалтай хийж оруулаагүй байна. Эдгээр төслүүдийн нөлөөллийн талаарх мэдээллийг олон хэсэг дамнан дурдсан нь ялангуяа олон улсын нисэх буудал, цахилгаан станцын нөлөөллийн үнэлгээ нь салангид, хэсэгчилсэн дутмаг мэдээлэл мэт харагдаж байна. Үүний оронд “Хамаарах байгууламжууд” гэсэн бүлэгт багтааж хэлэлцүүлэх нь илүү үр бүтээлтэй болох байжээ.

7.1 Олон улсын нисэх онгоцны буудлын гол нөлөөллийг БОННУ-нд тусгаагүй байдал

БОННУ-нд тусгаснаар Ханбумбат дахь Олон улсын нисэх онгоцны буудлыг төслийн барилгын ажил дуусмагц бүсийн буудал болгон ашиглах зорилгоор холбогдох албадад шилжүүлнэ⁵¹ гэжээ. Гэтэл, төслийн хэрэгцээ байгаагүй бол энэ нисэх буудлыг барьж байгуулах шаардлага байгаагүй бөгөөд төслийн хэрэгцээг хангах аас өөр эрэлт хэрэглээ хязгаарлагдмал байх юм. Иймд энэ нисэх буудлыг төсөлд хамаарах байгууламж гэж үзэж бүрэн хамжээний байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх нь зохистой байна.

Одоогийн байдлаар, нисэх буудлын нөлөөллийг газар ашиглалт болон дуу чимээгээр хязгаарласан байна. БОННУ-ний аль ч бүлэгт нисэх буудлын барилгын болон ашиглалтын явцад шаардагдах усны нөөцийн талаар үнэлгээ оруулаагүй байна. Ийм мэдээлэл хуримтлагдах болон хам нөлөөллийн хэсэгт ч багтаагүй байна. Өмнөговийн хувьд усны нөөцийн менежмент асар чухал байхад энэ нисэх буудлын усны нөөцөд нөлөөлөх байдлыг үнэлээгүй байгаа нь түшгүүртэй байна.

7.2 Нэгтгэсэн БОННУ-нд нүүрсээр галлах цахилгаан станцын байгаль орчин, нийгэмд нөлөөлөх үнэлгээг багтаах шаардлага

МУ-ын ЗГ-тай 2009 онд байгууласан Хөрөнгө оруулалтын гэрээгээр төслийн дөрөвдэх жилд Монгол дахь эх үүсвэрээс эрчим хүч татах үүрэг авсан байдаг. Төсөл нь эрчим хүчнийхээ хэрэгцээг хангах өөрийн цахилгаан станц бариулах эсвэл Монголын ТЭХС-ээс хангагдаж болно гэж Гэрээнд заасан боловч төслийн эрчим хүчний хэрэгцээг сүүлчийн вариантаар хангах боломжгүй юм. Төслийн танилцуулгаас үзвэл, цахилгаан станцын хувьд тусдаа БОННУ хийлгэхээр байна. Цахилгаан станцаас бий болох хам нөлөөллийн талаар зурвасхан дурдсан боловч тухайлбал усны хэрэглээний талаар маш хангалтгүй мэдээлэл байна.

Энэ төсөл байгаагүй бол баригдах шаардлага байхгүй тул цахилгаан станц нь хамаарах байгууламж бөгөөд үүнд тусгайлан БОННУ хийлгэх гэж байгаа нь сайшаалтай зүйл. Гэхдээ, нүүрснээс үүсэх сөрөг нөлөөллийг харгалзан одоогийн хэлэлцүүлж байгаа БОННУ-гээг цахилгаан станцын нарийвчилсан үнэлгээгүйгээр бүрэн гүйцэд гэж хүлээж авах боломжгүй юм. Жишээлбэл, энэ төслийн хувьд хүлэмжийн хийн хаягдал эсвэл уур амьсгалд нөлөөлөх хам нөлөөллийг тооцсон мэдээлэл байхгүй байна. Мөн энэхүү өөрийн хэрэгцээний цахилгаан станцын оронд нүүрс ашиглахгүй өөр альтернатив хувилбарыг судалсан мэдээлэл бас алга байна. Энэ нь ялангуяа цахилгаан станц барьж байгуулах ажлыг түргэтгэх зорилгоор төлөвлөгөөг 2 жилээр урагшлуулж байгааг харгазвал энд зайлшгүй багтаах ёстой баймаар⁵². Монгол улс нь нар, салхи мэт

⁵¹ OT ESIA, Chapter A1, p 13

⁵² Мөн тэнд

сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хөгжүүлэхэд маш зохимжтой нөхцөлтэй улс бөгөөд Оюу Толгой эдгээр эх үүсвэрийг хэрэглэж нүүрснээс хараат байдлаас гарах, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийх боломж байгаа юм. Сьерра Клубээс хийсэн нягтлалд дурдсан *Хөгжил ба Уур амьсгалын өөрлөлтийн Стратеги Хүрээ бодлогын Нүүрсний төслүүдийг шалгаруулах үзүүлэлтүүд* бодлогоор шаарддаг альтернатив шийдлийн анализийг хийлгэх нь компанийн экологийн ул мөр болон нэр хүндэд эерэгээр нөлөөлөх юм⁵³. Иймд дээрх шаардлагыг хангасан альтернатив хувилбарын анализ бүхий нарийвчилсан БОННУ хийгдэж холбогдох бүх талууд болон мэргэжилтнүүдээр хэлэлцүүлж зөвшилцөлд хүртэл санхүүжилт хийх асуудал яригдах үндэслэл алга байна.

7.3 Зам ба бусад дэд бүтцийн нөлөөллийг хангалтгүй тусгасан байдал

Газар ашиглан хөгжүүлэгчийн хувьд Оюу Толгой болон өмнийн Говийн бүсэд уурхай ашиглагч бусад компаниуд бүгд өөрийн зам, төмөр зам, эрчим хүчний шугам зэрэг дэд бүтцийн төслүүд байгуулж байна. Гэтэл, Оюу Толгойн барьж буй зам, өндөр хүчидлийн шугамууд нь бэлчээр тасдаж, эвдэж доройтуулснаар нутийн нүүдэлч малчид, мал амьтан, байгалийн экосистем болон ан амьтанд үлэмж сөрөг нөлөө үзүүлж байна. Оюу Толгойн зам ба өндөр хүчидлийн шугамууд нь Монгол-Хятадын Гашуун-Сухайт дахь хилийн боомт хүрэхийн тулд Бага Говийн ТХГ, Галбын говийн Шувуу нутаглах чухал газрууд зэрэг ховордсон ан амьтан, шувууны нутгаар дайран гардаг юм.⁵⁴

БОННУ-нд зам ба бусад тээврийн дэд бүтцээс малчдын өвөлжөө, худаг ус, бэлчээрийг тасдан салгаснаас малчид, тэдний мал амьтанд үлэмж сөрөг нөлөө учирна гэжээ.⁷⁰ Ан амьтны нүүдэллэх замын талаар хангалттай мэдээлэл судалгаа байхгүй, замыг хаагуур хэрхэн гарахыг мэдэхгүй тул зам барих ажил мөн ан амьтанд сөргөөр нөлөөлөх нь тодорхой. Ан амьтан зам гарах гарц байгуулах шаардлагыг зам, төмөр зам байгуулах зөвшөөрлийн дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд багтаана. Боломжтой газар нь тээврийн сүлжээ байгуулж ан амьтан нүүдэллэх замд учрах сөрөг нөлөөллийг буруулна⁵⁵.

Зам болон дамжуулах дэд бүтцийн сөрөг нөлөөллийн тухай бэлэн мэдээлэл байдгийг ашиглан БОННУ-нд Оюу Толгойн зам, өндөр хүчидлийн шугам болон дэд бүтцийн коридорын нөлөөллөөс болж нутаглах газаргүй болсон бүсийн малчид, байгалийн төрөл зүйлийн нүүдэллэх ба үржлийн газар, үйл явцад учрах хам болон хуримтлагдах нөлөөллийг тооцож болох байсан. Таван Толгойн нүүрсний зам ба төмөр зам нь голдирлыг нь өөрчлөх аюулд орсон Ундайн голыг хэд хэдэн газар хааж боосон байдаг нь усны адагт амьдрах хүн ам, ан амьтанд ямар нөлөөтэй байх нь тодорхойгүй байна. Харамсалтай нь БОННУ-нд эдгээр хам нөлөөллүүд болон эдгээрийг сааруулах арга хэмжээний талаар мэдээлэл тусгаагүй байна.

⁵³ Хавсаргасан тайланг үзнэ үү. Оюу Tolgoi copper\gold Mine Associated Power Plant: Violation of IFC & World Bank Policies on Environmental Impacts and Criteria for Coal Projects”, The Sierra Club

⁵⁴ Бага Говийн ТХГ-ын А ба Б хэсгүүдийг Чухал хабитат бөгөөд Олон улсын байгаль хамгаалах холбооны Ib – Wilderness Area ангилалд багтаасан байдаг. Галбын Говийн шувуу нутаглах чухал газрууд (ИВА) энэ А ба Б хэсгүүдэд болон хамгаалалтад аваагүй газруудад оршдог. Монгол улс Боннын конвенцийг баталсан тул Галбын говийн ИВА-д нутаглах устах эрсдэлд орсон шувуу, хөхтөн амьтныг хамгаалах үүрэг үүссэн байна. ⁷⁰ ОТ БОННУ, Бүлэг С12, р 4.

⁵⁵ ОТ БОННУ, Бүлэг С13, х 9

2011 оны 5 дугаар сард (түр хугацаагаар хаалгасан үр дүнтэй), дараа нь 2012 оны 8, 9 дүгээр сард замын тоос, чимээнээс учирч буй сөрөг нөлөөлийг эсэргүүцэж шороон замуудыг хааж байсан түүхтэй. Энэ эсэргүүцэл нь “нийгмийн үймээний хэлбэр” бөгөөд Оюу Толгой “0” сөрөг нөлөө⁵⁶ үзүүлнэ гэсэн бодлогоо хэрэгжүүлэхгүй байгаагийн илрэл юм. Үйлдвэрлэл эхлэх цагт тээвэрлэлт нэмэгдэж сөрөг нөлөө ихсэх боловч Оюу Толгойн БОННУ энэ тухай таг чимээгүй.

Хам нөлөөллийг зохистой байдлаар үнэлж үзэхийн оронд гомдол гараад байгааг үл харгалзан комданиуд өөр өөрслийн дэд бүтэц байгуулах ажлаа үргэлжлүүлсээр байна. Оюу Толгой энэ асуудлыг дараах байдлаар тойрох гэж оролдож байна

Оюу Толгойтой холбоотой сайжруулсан зам ба тээврийн бага зэргийн хам нөлөөлөл нь одоогийн нүүрсний тээвэрлэлтээс шалтгаалах бөгөөд доод хэмжээнд байх юм. Энэ нь Оюу Толгойн зүгээс өөрийн замын бэлчээр тасдах нөлөөллийг бууруулах ажил нь нийт бүсэд явагдаж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах хүлээлт байх учиргүй бөгөөд бусад замууд дээр ижил төрлийн нөлөөлөл саруулах ажил хийгдээгүй тохиолдолд үр дүн муутай байх юм⁵⁷.

Компани нь ан амьтны нүүдэллэх замын тухай мэдээлэл байхгүй гэж тайлагнасан нь нөлөөллийг бага хэмээн үнэлж өөрийгөө хариуцлагаас бүрэн чөлөөлөхийг санаархал байна. Ингэж үнэлсэн нь АНУ-ын ОУХА-ийн тайлан⁵⁸ болон бусад мэргэжилтнүүдийн гаргаж тавьсан асуудлуудад хариулт болж чадахгүй байна. Эдгээр замуудын хам нөлөөллийн үнэлгээ хийгээгүй нь ноцтой дутагдал бөгөөд Таван Толгойтой зам тээрийн дэд бүтцийн зохицуулалт хийвэл байгаль орчин ба нийгэмд учрах сөрөг нөлөөллийг үлэмж хэмжээгээр бууруулах боломж байгаа юм. Энэ хам нөлөөллийг нарийн судалж байж санхүүжилтийн асуудлыг шийдэх нь зөв байна.

Бодлогын зөрчил

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 1, догол мөр 8 ба ишлэл 15 (2012): Төслийн нөлөөллийн хүрээнд дараах эрсдэл ба нөлөөлөлд багтана: “Төслийн үндсэн хэсгээс тусдаа санхүүжилттэй, төсөл байгаагүй бол баригдах эсвэл өргөтгөл хийгдэхгүй байх, тэдгээргүйгээр төсөл амжилттай хэрэгжихгүй Хамаарах байгууламжууд болно [Хамааралтай байгууламжид төмөр зам, зам, өөрийн цахилгаан станц эсвэл өндөр хүчидлийн шугам, дамжуулах хоолой, ус дулаан г.м. дэд үйлчилгээ, агуулах болон бусад логистикийн терминал зэрэг багтана].”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 3, догол мөр 7 (2012): “Үйлчлүүлэгч нь төслөс шалтгаалах хүлэмжийн хийг бууруулах зорилгоор төслийн дизайн болон үйлдвэрлэлийн шатанд алтернатив боломжуудыг судалж, технологи ба санхүүгийн үндэслэл гаргаж, нийт үр ашгийн хувьд оновчтойг сонгоно.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 1, догол мөр 5 (2006): Төслийн нөлөөллийн хүрээнд дараах эрсдэл ба нөлөөлөл багтана: “(ii) төслөөс санхүүжихгүй Хамааралтай байгууламжууд (санхүүжилтийн Үйлчлүүлэгч тусад нь гаргасан эсвэл гуравдагч тал, түүний дотор засгийн газраас санхүүжсэн), төсөл амжилттай хэрэгжихэд

⁵⁶ Гудланд, хх 5-6

⁵⁷ ОТ БОННУ, Бүлэг С13, х 20-21.

⁵⁸ EGAT Oyu Tolgoi Trip Report, Johnston, p 8

зайлшгүй шаардлагатай болон өөрийн үйл ажиллагаа, оршин тогтох нь төслөөс бүрэн хамааралтай байгууламжууд орно.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 3, догол мөр 11 (2006): “Үүний дээр, Үйлчлүүлэгч нь төслийн дизайн ба үйлдвэрлэлийн шатанд хүлэмжийн хий бууруулах эсвэл офсет хийх боломжит технологийн болон санхүүгийн үндэслэл, үр ашгийн тооцоо бүхий сонголт хийнэ.”

8. Хам нөлөөлөлүүд

Хам нөлөөллийг дараах байдлаар тодорхойлдог:

Одоо хэрэгжиж байгаа, бэлтгэгдэж буй болон ирээдүйд орж ирэх төслүүдээс бий болгох нэг төслийн нөлөөллөөс давсан олон төрлийн сөрөг эсвэл эерэг нөлөөллүүдийн хам үйлчлэл⁵⁹ гэнэ.

Усны нөөцийн менежмент мэт нутгийн иргэд, шинжлэх ухаан, холбогдох салбаруудын мэргэжилтнүүдийн санаа зовж буй нөлөөллүүдийг БОННУ-нд тусгадаг ёстой. Оюу Толгойн БОННУний Хам Нөлөөлөл сэдэвт хэсэгт Дэлхийн Банкнаас өмнийн Говийн бүсэд хийсэн судалгаануудын танилцуулга гэлтэй.⁷⁶ Гэтэл, эдгээр судалгааны олон зам харгуй ан амьтны нутаглах газруудыг таслан экологийн саад, бүсийн гүний усны нөөцийн үнэлгээ хийх шаардлагын талаарх Дэлхийн Банкны зөвлөмжүүдийг үл харгалзан төслөө хэрэгжүүлэх гэж байна. Уул уурхайгаас байгаль орчин учруулах зарим сөрөг нөлөөллийн улам даамжруулдаг уур амьсгалын өөрчлөлтийг бусад бүх хүчин зүйлүүд дээр “нэмэгдэл хүчин зүйл” болгон Хам нөлөөллийн үнэлгээнд тооцож тогтоодог ёстой.

Бодлогын зөрчил

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 1, догол мөр 8 (2012): Төслийн нөлөөллийн хүрээнд дараах эрсдэл ба нөлөөлөл багтана: “Төслийн ашиглаж буй газар эсвэл нөөцөд шууд болон шууд бусаар хэсэгчлэн нөлөөллөх нөлөөлөл ба эрсдлийг тогтоох үед тухайн төсөл, бусад зэрэгцэн хэрэгжиж буй, төлөвлөгдсөн болон боловсруулах шатанд байгаа туслүүдээс учрах хам нөлөөллийг тооцно.”

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 1, догол мөр 5 (2006): Төслийн нөлөөллийн хүрээнд дараах эрсдэл ба нөлөөлөл багтана: “(iii) төслийг хөгжүүлэх төлөвлөлт, хэрэгжиж байгаа бусад төсөл эсвэл нөхцөл байдал болон Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн байдлыг үнэлгээ хийгдэх үед хэрэгжүүлэх нь тодорхой болсон

⁵⁹ IFC Policy & Performance Standards and Guidance Notes, Glossary of Terms [http://www.ifc.org/ifcext/enviro.nsf/AttachmentsByTitle/pol_PerformanceStandards2006_glossary/\\$FILE/Glossary+of+Terms.pdf](http://www.ifc.org/ifcext/enviro.nsf/AttachmentsByTitle/pol_PerformanceStandards2006_glossary/$FILE/Glossary+of+Terms.pdf)

⁷⁶ Namely the following: Walton, T. 2010. *Southern Gobi Regional Environmental Assessment*. Mongolia Discussions Papers, East Asia and Pacific Sustainable Development Department, Washington D.C.: World Bank; Tuinhof, A. and Buyanhisnig, N. 2010. *Groundwater Assessment of the Southern Gobi Region*. Mongolia Discussions Papers, East Asia and Pacific Sustainable Development Department, Washington D.C.: World Bank; and Warlters, M. 2009. *Southern Mongolia Infrastructure Strategy*: World Bank.

тухайн төсөлд хамаарах үйл ажиллагаа; мөн (iv) төлөвлөгдөөгүй боловч нөлөөлөл учрахыг урьдчилж таамаглаж болох эсвэл өөр газар орших төслийн болзошгүй нөлөөллийг тооцно.”

8.1 Бүсийн усны нөөцийн хэрэглээний болон ирээдүйн болзошгүй хил дамнасан нөлөөллийг БОННУ-нд багтаагаагүй байдал

Өмнөговийн Оюу Толгойгоос 200 км радиус газар нутагт арав гаран ашиглалтын лиценз олгогдсоны томоохноос нь дурдвал Таван Толгойн нүүрсний уурхай, Цагаан суврага дахь зэсийн орд байгаа нь Оюу Толгойгоос илүүгүй гэвэл дутахгүй хэмжээний усны нөөц шаардагдах дэлхийд томд орд ордууд юм. Ус нь Өмнөговийн хамгийн ховор баялаг бөгөөд эдгээр гурван том уурхайн гүний – энэ бүсийн үндсэн нөөц- усыг хэрэглэх өрсөлдөөн нь хэд хэдэн Европын улс гүрний хоорондын усны маргаантай зүйрлэж болох зүйл. Хам нөлөөллийн үнэлгээний хэсэгт энэ болон бусад төслүүдийн хувьд улс төрийн эрсдэл болж болзошгүй усны нөөцийн асуудлыг огт дурдаагүй байна.

Хэрэв энэ бүсэд төлөвлөгдсөн уул уурхай, дэд бүтцийн хөгжил үргэлжилбэл гүний усны нөөц 2020 он гэхэд шавхагдана гэж БОННУ-нд мэдэгдсэн байна.⁶⁰ Ийм тохиолдолд гүний усны нөөцийн дээр Монголын хойт зүгээс гадаргын ус татах шаардлага гарна. Өнөөдрийн байдаар дээрх нөхцөл байдал бодит амьдралд тулгарах магадлал өндөр байгаа нь ирээдүйд гадаргын ус татах төслүүдээс нийлүүлэх усанд найдах нөхцөл үүсч болзошгүй гэснээр нотлогдож байна. Иймд Оюу Толгой одоогоор дээрх холын зайнд ус татах төслүүдээс ус хэрэглэхээр төлөвлөөгүй хэмээн үгүйсгэхийн оронд БОННУ-ндээ эдгээр төслүүдийн нөлөөллийн үнэлгээ хийх нь зохистой байна.

Өмний Говийн гүний усны нөөцөд уул уурхайн салбараас учруулах дарамтыг сааруулахын тулд Монголын Засгийн газар Орхон ба Хэрлэн голуудын усыг татахаар төлөвлөж байна. Дэлхий Банк өнөөдөр Уул уурхайн дэд бүтцийг дэмжих хөтөлбөр (MINIS)-ийнхээ хүрээнд Орхон-говийн техникийн даалгавар боловсруулах ажлыг хэрэгжүүлж байгаа бөгөөд Хэрлэн-Говь төслийн техникэдийн засгийн үндэслэл боловсруулах ажил эхлээгүй байна. Хоёр төсөл хоёул байгаль орчин болон голын сав газруудад амьдрах хүн амд нийгмийн сөрөг нөлөө өндөртэй байхаас гадна хил дамнасан нөлөөлөлтэй байх юм. Хэрлэн гол жишээлбэл, Хятад улсын Өвөр Монголын Далай нуурыг тэжээдэг байна. Орхон гол нь (Монголын хамгийн урт гол) ОХУ-ын Байгаль нуурыг тэжээдэг Сэлэнгэ мөрөнд цутгадаг гол юм. Роберт Гудландын тэмдэглэснээр, Байгаль нуур, Далай нуур аль алин НҮБ-ын

Рамсарын конвенцийн хүрээнд хамгаалагдсан газрууд юм.⁶¹ Өмнөговид уул уурхайн хөгжлийн улмаас усны хэрэгцээ нэмэгдвэл дээрх төслүүдийг хэрэгжүүлэхийг Дэлхийн Банк өөрөө бараг баталж, БОННУ-нд мөн дурдсан атлаа эдгээр голуудын усыг эргүүлэх төслүүдээс үүсэх хил дамнасан нөлөөллүд, улмаар НҮБ-ын Рамсарын конвенц зөрчих асуудлыг Хам нөлөөллийн хэсэгт багтаагаагүй нь дутагдалтай байна.

⁶⁰ ОТ БОННУ, Бүлэг С13, х 5

⁶¹ Гудланд, х 5

8.2 Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн хаягдлын асуудлууд хангалттай тусгагдаагүй

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн хувьд дэлхийн дундаж температурын өсөлтөөс өндөр байгаа Монгол улс өвөрмөц, онцгой байдалд байна. Ган, зуд, цөлжилтийн үйлчлэл орон нутгийн хүн амд дарамт болоод байгаа энэ үед БОННУ-нд уур амьсгалын өөрчлөлтөөс усны нөөцийг хамгаалах, экосистемийн үйлчилгээ болон нийтийн эрүүл мэнд зэрэг чухал асуудлуудыг багтааж үнэлээгүй байна.

Жишээлбэл, байгалийн төрөл зүйлийн хувьд, “өмнө зүгт [Монголын] цөлжилт илүү газар авах хандлагатай. 2050 он гэхэд ойн сангийн хорогдол болон суурин хүн ам нэмэгдсэнээс нүүрс хүчлийн агууламж зэрэг үлэмж үр дагавар экосистемийн үйлчилгээнд нөлөөлнө.⁶² Уур амьсгалын өөрчлөлт, бүсийн биомын шилжилтээс бий болох экологийн нөлөө, эдгээр нь уурхай болон хаалтын дараах нөхөн сэргээлтэд хэрхэн нөлөөлөх тухай БОННУ-нд тусгаагүй байгаа нь ноцтой, хүлээн авч болохгүй дутагдал юм.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах нэн чухал арга хэмжээний нэг бол хүлэмжийн хийн хаягдлыг хэмжих ба бууруулах ажил ордог. Төслийн талбай дахь дизель генератор, их оврын болон авто техникийн утаа зэргээс хүлэмжийн хийн хаягдал өндөр байна гэдэг БОННУ-нээс харагдаж байна.⁶³ Гэтэл, БОННУ-нд түлшийг уурхайн талбай руу хэрхэн хүргэх болон үүнээс үүсэх байгаль орчны нөлөөллийг дурдаагүй байна. БОННУ-нд мөн төлөвлөгдөж буй 450 мегаватын нүүрсээр галлах цахилгаан станцаас гарах хийн хаягдлыг тооцоогүй байна. Хүлэмжийн хийн хаягдлыг хэмжих, бууруулах тодорхой төлөвлөгөө байхгүй болон дэд бүтцийн коридор барьж байгуулах зорилгоор 70 км орчны заг, хайлас модны ойг устгаж байгаа нь нүүрс хүчлийн тэнцвэрт байдлыг тогтоогоогүй бөгөөд тогтоох нөхцөлийг үгүйсгэсэн байна.⁶⁴

БОННУ-нд Оюу Толгойн хүлэмжийн хийн хаягдлаас учрах нийгмийн өртгийг тооцож тоон баримтаар гаргаагүй байна. Дэлхий дахины Байгаль ба Хууль Альянсын дүгнэснээр БОННУ-нд төсөл үргэлжлэх хугацааны нийгмийн өртгийг Штернийн аргачлалаар өнөөдрийн үнээр үнэлвэл \$1.5 тэрбум доллар⁶⁵ хүрч байгаа нь Засгийн газар ба хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахдаа сайтар бодолцох тоо байна.⁷⁴

Бодлогын зөрчил

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 1, догол мөр 7 (2012): “Эрсдэл ба нөлөөллийг тогтоох үйл явцад хүлэмжийн хийн хаягдал, уур амьсгалын өөрчлөлтөд холбогдох эрсдлүүд болон дасан зохицох боломж, болзошгүй хил дамнасан нөлөөлөл, түүний дотор агаарын бохирдол, эсвэл хил дамнасан усны хэрэглээ ба нөлөөллийг үнэлнэ.”

⁶² Song, x 5

⁶³ ОТ БОННУ, Бүлэг С2, х 20

⁶⁴ Гудланд, х 4

⁶⁵ Stern, N. 2007. *The economics of climate change: The Stern Review*. Cambridge: Cambridge University Press. This quantitative method was adopted by the World Bank in the Eskom power project in South Africa, and uses a value of \$29 per ton of CO₂ for a calculated 1,349,798 ton output during construction and 1,857,019 ton output for each year of production for 27 years as defined by Chapter C2 of the ESIA. ⁷⁴ Chernaik and Weiskel, x 16

ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 1, догол мөр 6 (2006): “Үнэлгээ нь мөн агаарын бохирдол, олон улсын усан замуудыг хэрэглэх ба бохирдуулах, хүлэмжийн хийн хаягдлын глобал нөлөөлөл зэрэг хил дамнасан нөлөөллийг тооцно.”

9. Зөвлөмж

БОННУ-нд орших бодлогын зөрчлүүд бусад дутагдлуудыг засч залруулах, хараат бус мэргэжлийн баг байгуулагдаж байгаль ба нийгмийн сөрөг нөлөөллийг сааруулах арга хэмжээг тогтоох, нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдийн асуудлыг ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандартын дагуу шийдэх ажлууд хийгдэхээс наана Дэлхийн Банкны Гүйцэтгэх захирлууд Оюу Толгой төслийг ОУСК ба ОТДБА-аас санхүүжүүлэх шийдвэрийг батлахгүй байхыг зөвлөнө.

Төслөөс байгаль орчин ба нутгийн иргэдэд үлэмж хэмжээний хохирол учруулаад байгааг харгалзан ирээдүйд учрах нөлөөллийг бодитой сааруулах зорилгоор БОННУ болон түүнд тусгагдсан нөлөөлөл сааруулах төлөвлөгөөнүүдэд өөрчлөлт оруулах шаардлагатай. Дэлхийн банк, ЕСБХБ, бусад олон улсын санхүүгийн байгууллагууд эдгээр өөрчлөлтүүдийг хийлгэх хөшүүрэг болгох зорилгоор өөрийн хөрөнгийг ашиглах боломжтой тул дараах ажлууд хийгдэхээс наана санхүүжүүлэх шийдвэрийг батлахгүй байхыг зөвлөж байна. Үүнд:

† Бүрэн гүйцэд БОННУ хийгдэж зохих ёсоор хэлэцүүлэгдэх. БОННУ-нд:

- Өмнийн Говьд хэрэгжиж буй төслүүдийн усны хэрэглээнд хам ба хуримтлагдах нөлөөлөл, түүний дотор хил дамнасан нөлөөллийн үнэлгээ хийлгэх
- Үйл ажиллагаа (үйлдвэрлэлийн) Менежментийн Төлөвлөгөө, түүний дотор Хаягдлын Менежментийн Төлөвлөгөө, Үйл ажиллагааны үе шатны Усны Менежментийн Төлөвлөгөө болох Уурхайн Хаалтын Төлөвлөгөө зэргийг багтаах;
- Бүх Хамаарах байгууламжуудын хамгийн сүүлийн үеийн тоо баримтад үндэслэсэн нарийвчилсан үнэлгээ, түүний дотор олон улсын нисэх онгоцны буудал ба цахилгаан станцын үнэлгээ;
- Өмнөговид хөгжүүлэх зам тээвэр ба дахин дамжуулах дэд бүтцийн сүлжээнүүдээс нутгийн малчид өрхүүдийн амьжиргаа, бүсийн ан амьтан, биологийн төрөл зүйлд учрах хам нөлөөллийн үнэлгээ хийлгэж хэлэлцүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлтөд нэмэрлэх нөлөөлөл, ялангуяа 450MW цахилгаан станцаас үүсэх сөрөг нөлөөлөл, түүний нийгмийн өртгийг тооцож үнэлэх; болон
- Улс төрийн, эдийн засгийн эрсдлийн үнэлгээ зэргийг багтаах эдгээр болно.

† Бүрэн гүйцэд БОННУ-г мэдээллээр хангах болон хянах хөндлөнгийн экспертудын баг байгуулах. Экспертуудын баг дараах асуудлуудыг хянах:

- Гидрологи;
- Тоосны бохирдол;
- Байгалийн төрөл зүйлийг хамгаалах;
- Хаягдлын менежмент; болон □ Газар ашиглалт ба нүүлгэн шилжүүлэлт.

- † Хараат бус мэргэжлийн баг бүрдүүлж нүүрсээр галлах цахилгаан станцын БОННУ болон холбогдох баримт бичгүүд, түүний дотор Дэлхийн банкны *Хөгжил ба Уур амьсгалын өөрлөлтийн Стратеги Хүрээ бодлогын Нүүрсний төслүүдийг шалгаруулах үзүүлэлтүүд* бодлогоор шаарддаг альтернатив шийдлийн анализийг хянах.
- † Элдэв арга хэрэглэн зохисгүй нөхөн олговорын гэрээнд гарын үсэг зуруулах одоогийн практикийг зогсоож, гэрээг ОУСК-ийн Үйл ажиллагааны Стандарт 5-д нийцсэн эсэхийг тогтоох, нийцүүлж хэрэгжүүлэх.
- † БОННУ-нд дурдсан бүх судалгаа ба тайлангуудын вебсайтуудын холбоосыг өгөх эсвэл компанийн вебсайтад тавих замаар олон нийтэд нээлттэй болгох. Үүнд:

Бүлэг В6: Усны суурь үнэлгээ

- Eco- Trade(2004): Oyu Tolgoi Project EIA Vol 1 Report of the Oyu Tolgoi to Gashhun Road and Infrastructure Corridor, Environmental Protection Plan and Environmental Monitoring Plan, Eco-Trade LLC, 2004.
- ESIC (2007): Oyu Tolgoi Project EIA report for the Oyu Tolgoi Project Domestic Airstrip Relocation, Environmental Study & Information Centre OC LLC, 2007.
- Eco- Trade (2005): Oyu Tolgoi Project Groundwater Resource Use from the Gunii Hooloi and Galbyn Gobi Regional Aquifers, , Eco-Trade LLC, 2005.
- Eco- Trade (2006): Oyu Tolgoi Project EIA Vol 3 Mining and Processing, Eco-Trade LLC, 2006.

Ус хангамжийн инженерийн дизайн – мэргэжлийн үнэлгээ

- Golder (2005): Draft Report on “Review of Feasibility Design, Tailing Storage Facility, Oyu Tolgoi Project Mongolia” Project No 05-1362-126, Prepared by Golder Associated Ltd., May 2005.
- Water Management Consultants [Shrewsbury] (2006): Review of hydrogeology & modelling, Feb 2006 □
- Black & Veatch (2008): Engineering review of overall water supply system, April 2008.
- Maison Worley Parsons (2010): Pipeline and Borefield Design Review.
- Acacia Water (2009), ref in Tuinhof and Buyanhisnig (2010)
- Aquaterra (2004): Groundwater Exploration Investigation, Oyu Tolgoi Process Water Supply, vols 1-5, inc vol 1: Resources Assessment and Borehole Design
- Aquaterra (2008): Gunii Hooloi Aquifer, Groundwater Investigation and Resources Assessment- 2007 [Revised water Demand], ref 658/F/331a, Aquaterra Consulting Pty Ltd, 2008
- Aquaterra (2008): Gunii Hooloi Aquifer Detailed Design – Bore Design [Revised Water demand], ref 658/G/328b, 2008
- Aquaterra (2010): Oyu Tolgoi Mine Site Hydrological Assessment report, re U25D/111c, 2010.

Ханбогд сумын усан хангамж

- Geomaster Engineering (2010): Report on Groundwater Geophysical Exploration for Water Supply of Khanbogd Soum, Omnogovi Province

Уурхайн хаягдлын менежмент

- Oyu Tolgoi (2009), Mongolian Feasibility Study, Attachment Section 10, Process - Tailings Storage Facility Subsection 7

- Golder (2005): Draft Report on “Review of Feasibility Design, Tailing Storage Facility, Oyu Tolgoi Project Mongolia” Project No 05-1362-126, Prepared by Golder Associated Ltd., May 2005.
- Klohn Crippen Berger (2010): Oyu Tolgoi Tailings Storage Facility
- Klohn Crippen Berger (2011): Oyu Tolgoi Tailings Storage Facility 2010 Feasibility Study Update report

Ундайн голын гольдирлын өөрчлөлт

- SMEC (2011): Oyu Tolgoi Project: River Diversion Detailed Engineering Design Report- Final, Ref: A2MW-90-K487

Бүлэг С5: Усны нөлөөллийн үнэлгээ

- Aquaterra (2007), ref in Tuinhof and Buyanhisnig 2010.
- Oyu Tolgoi (2010): Preliminary Mine Closure Plan for Mongolian Feasibility Study, AMEC 2010.
- SMEC (2010) [as above]: ref A2MW-90-K
- Aquaterra (2010) [as above]
- Aquaterra (2010): personal comm. Nov 2010.
- SMEC (2007): Undai River Diversion Basic Engineering, Final report, SMEC 2007.
- Maison Worley Parsons (2010): Assessment of Subsidence on Pipeline for Raw Water Supply System, Doc ref A2MW-6100-00-EV043, Rev. B, Oct 2010.
- Knight Piesold Pty Ltd (2005): Oyu Tolgoi Project, Feasibility Study, Undai River Diversion, May 2005, Ref PE601-0001/18, Rev 1.
- Eco- Trade (2006): Detailed EIA Report for the Oyu Tolgoi Project, Mining and Processing, 2006
- CPR (2007): Perceptions Study on Water Use [see p28/65]
- JEMR Consulting LLC (2010): Amendment Detailed EIA Report on use of Gunii Hooloi underground water resource for Oyu Tolgoi Project, Oct 2010.
- MNS 6148 (2010): Sewage Discharge Standard

Чулуулаг хаягдлын менежмент

- EGI (2008): Oyu Tolgoi Project Acid Rock Drainage Review and Recommended Investigation Programme, for Ivanhoe Mines MN by Environmental Geochemistry International May 2008 □ Oyu Tolgoi (2010): personal comm. Nov 2010.

Холбоо барих хаяг:

Дүгэрсүрэнгийн Сүхгэрэл, Гүйцэтгэх захирал, Оюу Толгойн Хяналт ТББ, 99185828 otwatch@gmail.com

Jelson Garcia, Bank Information Center, +1 202 624 0622, jgarcia@bicusa.org

Sarah McNeal, Bank Information Center, +1 202 624 0622, smcneal@bicusa.org

Richard Harkinson, London Mining Network, +44 7563 238179, research@londonminingnetwork.org

Vladlena Martynkevych, CEE Bankwatch Network, +380 44 353 78 42, vladlena@bankwatch.org

Regine Richter, Urgewald, +49 3028482270, regine@urgewald.de

Sarah Singh, Accountability Counsel, +1 415 296 6761, sarah@accountabilitycounsel.org

